НИЙСЛЭЛИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ГАЗАР

2022 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ
2022.06.25

ТАЙЛАНГИЙН БҮТЭЦ, АГУУЛГА

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН.....2
1.1. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр 3
1.2. Үндэсний хөтөлбөрүүд.....3
1.3. Нийслэлийн засаг дарга бөгөөд улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр.....4
1.4. Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл 5
ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН.....6
2.1. Тогтоол шийдвэрийн хэрэгжилт 6
2.2. Шинэ төрлийн коронавирус /covid-19/-ийн халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлсэн ажил 7
ГУРАВДУГААР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН.....8
3.1. Дүрмээр хүлээсэн үүргийн хэрэгжилт 8
3.2. Бичил бизнесийг дэмжих, ядуурлыг бууруулах нийслэлийн хөтөлбөр 21
3.3. Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх төсөл.....23
3.4. Судалгаа 26
3.5. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр хэрэгжүүлсэн ажил 32
3.6. Хүний нөөцийн бодлого, үйл ажиллагаа.....33
3.7. Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, албан бичгийн шийдвэрлэлт 35
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ 37
4.1. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал.....37
ТАВДУГААР БҮЛЭГ. БУСАД МЭДЭЭЛЭЛ.....42
5.1. Түншлэл, хамтын ажиллагаа.....42
5.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ажилласан тухай 44
5.3. Дүгнэлт .....**Error! Bookmark not defined.**

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

Монгол Улсын Засгийн газрын болон Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, холбогдох хөтөлбөр арга хэмжээнд тусгагдсан хөдөлмөр эрхлэлтийн талаарх зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хууль, “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-ын дагуу байгууллагын үйл ажиллагааг төлөвлөж, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол, 2021 оны 374 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/335 дугаар захирамжаар тус тус хэрэгжилтийг тайлагнан ажиллаж байна.

Нийслэлийн хэмжээнд 15 ба түүнээс дээш насны хүн амын 534.137 буюу (54 хувь) нь ажиллах хүч, 460.325 буюу (46 хувь) нь ажиллах хүчнээс гадуурх хүн ам байна. Ажиллах хүч өмнөх оны мөн үеэс 70.290 буюу 13 хувиар өссөн, ажилгүй иргэн 1.226 буюу 2.6 хувиар буурсан байна. Ажилгүйдлийн түвшин 8.5 хувь байгаа нь өмнөх оны мөн үеэс 1.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Мөн ажиллах хүчний оролцооны түвшин 53.7 хувь, хөдөлмөр эрхлэлтийн түвшин 49.2 хувь байгаа нь өмнөх оны мөн үеэс ажиллах хүчний оролцооны түвшин 5.7 хувиар, хөдөлмөр эрхлэлтийн түвшин 6 хувиар тус тус өссөн эерэг үзүүлэлттэй байна.

Д/д	**Үзүүлэлт**	**2018**	**2019**	**2020**	**2021**	**2022 хагас жил**
1	Ажиллах хүч	555,350	529,460	552,141	519,420	534,137
2	Үүнээс: Ажиллагчдын тоо	513,054	470,996	517,427	482,757	488,934
3	Ажилгүй иргэдийн тоо	42,292	58,469	34,714	36,662	45,203
4	Ажиллах хүчнээс гадуурх хүн ам	484,262	436,118	468,530	485,220	460,325
5	Боломжит ажиллах хүч	-	24,917	37,526	27,376	25,558
6	Ажиллах хүчний оролцооны түвшин	53.4	54.8	54.1	51.7	53.7
7	Хөдөлмөр эрхлэлтийн түвшин	49.4	48.8	50.7	48.1	49.2
8	Ажилгүйдлийн түвшин	7.6	11	6.3	7.1	8.5

Манай улсад үйл ажиллагаа явуулж буй их, дээд сургууль, коллежийн тоо 2020-2021 оны хичээлийн жилд 88 байгаагийн 37 (42.1%) нь их сургууль, 45 (51.1%) нь дээд сургууль, 3 (3.4%) нь коллеж, 3 (3.4%) нь гадаадын их сургуулийн салбар байна. Үүний 65 (73.9%) нь хувийн, 20 (22.7%) нь төрийн өмчийн, 3 (3.4%) нь олон нийтийн, 1 шашны сургууль байна. Нийт сургуулийн 79 (89.8%) нь Улаанбаатар хотод, 9 (10.2%) хөдөө, орон нутагт байна.

Их, дээд сургууль, коллежид суралцагчдын тоо 2019-2020 оны хичээлийн жилд 148.4 мянга байсан бол 2020-2021 оны хичээлийн жилд 147.3 мянга болж, өмнөх хичээлийн жилээс 1.1 (0.7%) мянгаар буурсан байна.

1.1. ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих болон төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх 2 зорилт, 5 арга хэмжээний биелэлтийг 1 дүгээр улирал болон хагас жилийн байдлаар гарган, дээд шатны холбогдох байгууллагуудад тайлагнан ажиллалаа. Хөтөлбөрийн хэрэгжилтийн дундаж **55** хувьтай байна.

***Арга хэмжээний шалгуур үзүүлэлтийг хангасан байдал*:**

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь
1	Хөдөлмөрийн зах зээлийг орчин үеийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн шинэчилж, бүтээмж, үр дүнд суурилсан цалин хөлс, ажлын үнэлгээний систем нэвтрүүлж, зайнаас болон цагаар ажиллах уян хатан зохицуулалт бий болгон хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.	50%
2	“Цахим Монгол” арга хэмжээний хүрээнд хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарыг бүхэлд нь цахимжуулж, иргэдэд үзүүлэх үйлчилгээг ил тод, шуурхай, хүртээмжтэй болгоно.	70%
3	Орлого багатай өрхийн ажил эрхлэхгүй байгаа насанд хүрсэн гишүүдийг мэргэшил эзэмшүүлэх, ур чадварыг нь ахиулах сургалтад хамруулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.	30%
4	Гадаадад сурч, хөдөлмөрлөж байгаа Монгол иргэдийг дэмжих, эх орондоо эргэн ирж ажиллаж хөдөлмөрлөхөд дэмжлэг үзүүлэх хөдөлмөрийн бирж бий болгоно.	-
5	Төрийн байгууллагын үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэд, олон нийтийн оролцоог хангана.	70%
Нийт арга хэмжээний хэрэгжилтийн дундаж хувь		**55%**

1.2. ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРҮҮД

Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор батлагдсан холбогдох үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/335 дугаар захирамжийн дагуу Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар болон Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт тайлагнан ажиллалаа. Хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн дундаж **92.4** хувьтай байна.

Хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангасан байдал:

№	Үндэсний хөтөлбөр	Холбогдох зорилт, арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь
1	Хүүхдийн хөгжил хамгааллын үндэсний хөтөлбөр	1 зорилтын 1 арга хэмжээ	70%
2	Залуучуудын хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр	2 зорилтын 2 арга хэмжээ	100%
3	Ахмад настны хөгжил хамгааллын үндэсний хөтөлбөр	1 зорилтын 1 арга хэмжээ	100%

4	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр	2 зорилтын 2 арга хэмжээ	92%
5	Ажилгүйдэл, ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөр	3 зорилтын 4 арга хэмжээ	100%
Хэрэгжилтийн дундаж хувь			**92,4%**

1.3. НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр тусгагдсан 2 зорилтын 8 арга хэмжээний хэрэгжилтийг хагас жилийн байдлаар гарган, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсний дагуу Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлсэн. Хөтөлбөрийн хэрэгжилт **63.3** хувьтай байна.

***Арга хэмжээний шалгуур үзүүлэлтийг хангасан байдал*:**

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь
1	Залуучуудыг бизнес эрхлэх сургалт, арга хэмжээнд хамруулан, гарааны бизнес эрхлэлтийг дэмжинэ.	50%
2	Оюутан, залуучуудыг цагаар ажиллах боломж нөхцөлийг бүрдүүлэн, суралцах хугацаанд нь хөдөлмөр эрхлэлтийн түүхтэй болгоно.	50%
3	Хөдөлмөрийн зах зээлийн бүртгэл мэдээллийн систем болон цахим хөдөлмөрийн биржийг хөгжүүлэх замаар үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.	50%
4	Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд тохирсон цагийн болон түр ажлын байрыг нэмэгдүүлнэ.	70%
5	Мэргэжлийн болон давтан сургалтад иргэдийг хамруулан, тохирох ажлын байранд зуучилна.	70%
6	Бүтээмжийг нэмэгдүүлэх, ажлын цагийг богиносгох замаар байгууллагын урсгал зардлыг бууруулах мэдээлэл, нөлөөллийн аян зохион байгуулна.	-
7	Гадаадад сурч, хөдөлмөрлөж байгаа иргэдийг хөдөлмөрийн зах зээлийн мэдээ мэдээллээр хангах, ажлын байранд зуучлах өдөрлөгийг тогтмол зохион байгуулна.	-
8	Ажил олгогч, аж ахуй нэгж байгууллагуудад зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулна.	90%
Нийт арга хэмжээний хэрэгжилтийн дундаж хувь		**63.3%**

1.4. НИЙСЛЭЛИЙГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ

Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хүрээнд 2 зорилтын 7 арга хэмжээний хэрэгжилтийг хагас жилээр гарган Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст тайлагнан ажиллалаа. Эхний хагас жилийн байдлаар хэрэгжилтийн дундаж **61.4** хувьтай байна.

***Арга хэмжээний шалгуур үзүүлэлтийг хангасан байдал*:**

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь
1	Шинээр ажлын байр бий болгосон ажил олгогчдыг дэмжин, иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлсэн байна.	70%
2	“Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв”-ийг олон улсын жишигт нийцүүлж, бүсчилсэн байдлаар хөгжүүлж, хөдөлмөр эрхлэлтийн цогц үйлчилгээг хүргэсэн байна.	70%
3	Хөдөлмөр эрхлэлтийн сургалт, мэргэжлийн болон давтан сургалтыг бүрэн дунд түүнээс доош боловсролтой, мэргэжилгүй, ажлын туршлагатай залуу ажиллах хүчинд чиглүүлэн зохион байгуулсан байна.	70%
4	Оюутан залуучуудын цагийн ажил хийх нөхцөлийг бүрдүүлсэн байна.	70%
5	Залуучуудыг бизнес эрхлэх сургалт, арга хэмжээнд хамруулан гарааны бизнес эрхлэлтийг дэмжинэ.	50%
6	Бичил бизнес эрхлэгчдийг жижиг бизнес эрхлэгч болгох суурь нөхцөл бүрдсэн байна.	50%
7	Албан бус эдийн засгийн салбарт ажиллагсдыг албан салбарт шилжүүлж зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн байна.	50%
Нийт арга хэмжээний хэрэгжилтийн дундаж хувь		**61.4%**

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

2.1. ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ

Хууль дээдлэх зарчмыг баримтлан үйл ажиллагаандаа Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Шилэн дансны тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, болон өөрийн эрхлэх асуудлын хүрээний холбогдох хууль тогтоомжийг чанд мөрдөж, хэрэгжилтэд тогтмол хяналт тавин ажиллаж байна.

Дээд газрын тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг байгууллагын хэмжээнд мэдээллээр хангах, хяналтад авах, төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах байдлаар хэрэгжүүлэн ажилласан.

Оны эхэнд бодлогын болон эрх зүйн баримт бичгийн зүйл заалтыг эзэнжүүлж, тайлан мэдээ гаргах хуваарийг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Хөдөлмөр, нийгмийн хамгаллын сайдын 2017 оны А/121 дүгээр тушаал, Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/335 дугаар захирамжаар батлагдсан журмын дагуу гарган, газрын даргаар батлуулан ажиллаж байна.

2022 оны эхний хагас жилийн байдлаар Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон ХХҮЕГ-аас ирүүлсэн хууль, тогтоомжийн жагсаалтын дагуу Монгол улсын 5 хуулийн 14 заалт, Ерөнхийлөгчийн 2 зарлигийн 2 заалт, Засгийн газрын 3 тогтоолын 10 заалтын биелэлтийг гарган, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн дээд шатны байгууллагад хугацаанд нь хүргүүллээ. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн дундаж хувь **56.6** хувьтай байна.

Тайлант хугацаанд Нийслэлийн засаг даргын зөвлөлийн хурлын тэмдэглэлүүд, шинэ төрлийн коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай болон Нийслэлийн засаг даргын А/01, А/108, А/161, А/212, А/203, А/217, А/265, А/380, А/431, А/477, А/723, А/324, А/625, А/658, А/828 зэрэг 15 захирамжийн 32 заалтын хэрэгжилтийг тус тус 7, 14, улирлаар гарган L-monitoring програмд оруулсан.

ХХҮЕГ-т /цаасан суурьтай/			НЗДТГ-т /L-monitoring програм/			
Засгийн газрын тогтоол	ХНХСайдын тушаал	ХХҮЕГ-ын даргын тушаал	Засгийн газрын тогтоол	НЗД-ын захирамж	НОК-ын Хурлын тэмдэглэл	Нийслэлийн удирдлагаас өгсөн үүрэг даалгавар
2/8	-	-	2/10	15/32	2/12	13/56
17			89			
Нийт 32 тогтоол шийдвэрийн 62 заалт						

2.2. ШИНЭ ТӨРЛИЙН КОРОНАВИРУС /COVID-19/-ИЙН ХАЛДВАРААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖИЛ

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 01 дүгээр тогтоол, шинэ төрлийн коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын тэмдэглэлүүд, Нийслэлийн Засаг даргын 2022 оны холбогдох захирамжийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Тус байгууллага нь Коронавируст /Ковид-19/ цар тахалтай тэмцэх, хариу арга хэмжээний хүрээнд байгууллагын өрөө тасалгаа нийт 100 м.кв^2 талбайд 7 удаагийн давтамжтай ариутгал, халдваргүйжүүлэлтийг “Улаанбаатар ариутгал ХХК-иар хийлгэсэн.
- Албан хаагчдыг коронавирус /Covid-19/-ээс урьдчилан сэргийлэх вакцинд хамруулах зорилгоор дархлаажуулалтын талаарх хууль тогтоомж, холбогдох мэдээ, мэдээллүүдийг тухай бүр хүргэн ажилласан. 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар нийт албан хаагчид вакцины 3 тунд 100% хамрагдсан.
- Дээд газраас гарч буй захирамж, тушаал, шийдвэрийг албан хаагчдад тухай бүр шуурхай танилцуулж, нэг удаагийн амны хаалтаар ханган, ажлын байрандаа тогтмол амны хаалт хэрэглэх, гар барин мэндчилэхгүй байх заавар, зөвлөмж өгч, байгууллагын хэмжээнд шаардлагатай амны хаалт, гар ариутгагч болон ариутгал халдваргүйжүүлэлтийн 500,0 мянган төгрөгийн бараа, материалыг худалдан авсан.
- Улсын Онцгой комисс болон Нийслэлийн онцгой комиссын тушаал захирамжийн дагуу байгууллагын 0-5 хүртэлх насны хүүхэдтэй 9 албан хаагчийг 2022 оны 01 дүгээр сарын 19-нөөс 02 дугаар сарын 18-ныг хүртэл сарын хугацаанд албан үүргээ цахимаар гүйцэтгэх боломжоор ханган, утсан харилцаа холбоогоо 24 цагаар нээлттэй байлгах, цаг үеийн болон хугацаатай мэдээ, тайланг тухай бүр гаргаж, үр дүнг тайлагнан ажиллахыг үүрэг болгосон.
- Нийслэлийн Онгой комиссын даргын 2021 оны 15 дугаар тушаалын дагуу Баянзүрх дүүргийн 1, 2 дугаар хорооны иргэн аж ахуйн, нэгж байгууллагын ажилтан, албан хаагчдын дархлаа сэргээх нэмэлт тунгийн хамрагдалтын мэдээг, 2 дугаар хорооны түүхий нүүрсний хэрэглээ, сайжруулсан түлшний цэгийн тоо, нөөцлөлтийн мэдээг нэгтгэн Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын, Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс болон Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвийн Нийгмийн эрүүл мэндийн албанд тус тус хүргүүлсэн.

Шинэ төрлийн коронавирус /Covid-19/-ийн өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, ажлын хүрээнд байгууллагын үйл ажиллагаанд цахим системийг ашиглах тухай дээд шатны байгууллагаас өгч буй зөвлөмж, чиглэлийн дагуу дараах арга хэмжээг авч ажиллав. Үүнд:

1. https://ework.hudulmur-halamj.gov.mn/, https://erp.ulaanbaatar.mn/ системийг ашиглан, цахим хэлбэрээр албан хаагчдад үүрэг даалгаврыг өгч, гүйцэтгэлд хяналт тавин ажилласан.
2. Хурал, уулзалтыг UB ERP, Zoom зэрэг онлайн хурлын систем ашиглан цахимаар зохион байгуулан, дээд газраас зохион байгуулж буй хурал, уулзалтад цахимаар оролцож байна.
3. Дэлхийн ЭМБ, ЭМЯ-аас гаргаж буй тархалт, шинэ төрлийн коронавирус /Covid-19/-ийн халдвараас урьдчилан сэргийлэх тухай зөвлөмж, сэрэмжлүүлэг, гарын авлага, зурагт хуудсыг байгууллагын http://ubbirj.ub.gov.mn/ цахим хуудас болон салбар нэгжийн facebook хуудсаар тогтмол сурталчилж байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

3.1. ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ

Монгол Улсын Засгийн газрын болон Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, хөгжлийн бодлогын бусад баримт бичгүүдэд дэвшүүлсэн зорилттой уялдуулан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг хэрэгжүүлж, хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг нийслэлийн хэмжээнд зохион байгуулан ажиллаж, үйл ажиллагаандаа Төрийн албаны тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Шилэн дансны тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжийг чанд мөрдөж, хэрэгжилтэд тогтмол хяналт тавин ажиллалаа.

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭ

Тайлант хугацаанд Нийслэлийн хэмжээнд **2142** ажлын байр шинээр бүртгэж, **870** ажил олгогч байгууллагаас **8349** ажлын байрны захиалга хүлээн авч, **7539** ажил хайгч иргэнийг бүртгэн, **4477** иргэнийг тохирох ажлын байранд зуучилснаас **3769** нь буюу **84.1** хувь нь ажилд орсон байна.

Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн Дүнжингарав салбарт байрлах “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв” нь ”Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ үзүүлэх байгууллагад тавих шаардлага” MNS:6620-2016 стандартын дагуу иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад хөдөлмөр эрхлэлтийн цогц үйлчилгээг нэг цэгээс үзүүлж байна. 2022 оны хагас жилийн байдлаар 167 ажил олгогчын 3001 ажлын байрны захиалгыг төвлөрүүлж, давхардсан тоогоор нийт **11545** иргэн, ажил олгогчид дараах байдлаар үйлчилгээ үзүүлсэн байна. Үүнд:

- Бүртгэсэн ажил хайгч иргэн-1475
- Ажлын байранд зуучилсан иргэн 2200 /үүнээс ажилд орсон 1652/
- Цахим өдөрлөгт хамрагдсан иргэдийн тоо 871
- Дундын оффисоор үйлчлүүлсэн иргэн 502
- Хүүхдийн өрөөгөөр үйлчлүүлсэн иргэн 346
- Шийдвэрлэсэн санал хүсэлт 899
- АМЧБО бүлгийн сургалтад хамрагдсан иргэн 654
- АМЧБО ганцаарчилсан зөвлөгөөнд хамрагдсан иргэн 864 тус тус байна.

Тайлант хугацаанд үзүүлсэн хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг өмнөх оны мөн үетэй харьцуулан харуулбал:



Өмнөх оны мөн үетэй харьцуулахад цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан ажилд зуучлагдсан иргэдийн тоон үзүүлэлт буурсан ч ажлын байрны захиалгын тоо болон ажилд орсон иргэдийн тоон үзүүлэлт өссөн байна.

<u>Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээ</u>

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвөөр үйлчлүүлсэн 1518 иргэнд үзүүлсэн ба ганцаарчилсан зөвлөгөө мэдээлэлд **864** иргэнийг, бүлгийн сургалтаар **654** иргэнийг хамруулсан байна.

Үйлчилгээнд хамрагдсан нийт иргэдийн боловсролын түвшин, зөвлөгөө, мэдээллийн төрөл, насны бүлгээр эзлэх хувийг дэлгэрэнгүй харуулбал:





Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээнд хамрагдсан иргэдийн 62.6% нь бүрэн дунд боловсролтой, 15-24 насны залуучууд эзэлж байгаа бөгөөд дийлэнх нь хөдөлмөр эрхлэл болон мэргэжил сонголтын талаар зөвлөгөө мэдээлэл авсан байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвд сар бүрийн 15-ны өдөр Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих өдөрлөгийг нийт 4 удаа зохион байгуулсан ба хөгжлийн бэрхшээлтэй болон түүний асран хамгаалагч нийт **81** иргэнд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээг бүлэг болон ганцаарчилсан хэлбэрээр үзүүлсэн.

Нийслэлийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газраас ирүүлсэн хүсэлтийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асран хамгаалагч **38** иргэнд хөдөлмөрийн зах зээлийн мэдээ, мэдээлэл өгч, **3** иргэнд ганцаарчилсан зөвлөгөө өгч ажилласан.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвд Өрхийг гэрээт малчнаар ажиллуулах арга хэмжээнд хамрагдах иргэдийг 2022 оны 05 дугаар сарын 14-ний өдрөөс хүлээн авч, ганцаарчилсан зөвлөгөө мэдээллийг өгч, үйлчлүүлэгчийн хөдөлмөр эрхлэхэд бэлэн байдлын үнэлгээг 14 өрхийн 28 хүнд хийж, хөдөлмөр эрхлэх хувийн төлөвлөгөөг боловсруулан, бичиг баримтын бүрдлийг хангасан.

Нийслэлийн жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих төв НӨҮГ-тай хамтран 2022.03.14–2022.03.31-ний хугацаанд “Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль”-ийн хэрэгжилтийн хүрээнд жижиг, дунд үйлдвэрлэгч **129** иргэдэд Хөдөлмөр Эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс баталсан 2022-2023 онд хэрэгжүүлэх хөтөлбөрүүдийн мэдээллийг хүргэж ажилласан ба ажил хайгч иргэдийг зөвлөгөө мэдээллээр хангаж ажилласан.



Ажилд зуучлах үйлчилгээ

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв нь ажилд зуучлах үйлчилгээг чанартай, түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэх, иргэд ажил мэргэжлийн ирээдүйгээ зөв баримжаалж, сурч, ажиллаж, хөгжих боломж, нөхцөлийг бүрдүүлэх, улмаар хүн амын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд эерэг нөлөө үзүүлэх зорилгоор үйл ажиллагаагаа зохион байгуулан хэрэгжүүлдэг.

Стандарт, хэмжил зүйн газраас 2016 онд баталсан “Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ үзүүлэх байгууллагад тавих шаардлага” MNS:6620-2016 Монгол улсын стандартын дагуу ажлын байрны нөхцөл, хүний нөөц, ажилтан, албан хаагч, мэргэжлийн харилцаа, хориглох зүйл, үйлчилгээний төрөл хэлбэр, үр дүн, шалгуур үзүүлэлт зэрэг ерөнхий 5 шаардлага, 21 шалгуур үзүүлэлтийг ханган ажиллаж байна.

Ажилд зуучлах үйлчилгээний хүрээнд **167** ажил олгогч байгууллагатай хамтран ажиллаж, 3001 ажлын байрны захиалгыг төвлөрүүлж, **1475** ажил хайгч иргэнийг шинээр бүртгэн, **2200** иргэнд тохирох ажлын байрыг санал болгосноос **1652** иргэн ажилд орсон байна. Ажлын байр санал болгосон иргэдийн **75%** нь ажилд орсон бөгөөд энэ нь тохирох ажлын байранд зуучлах /Job matching/ буюу ажилд зуучлах үйлчилгээний чанарын үзүүлэлтийг харуулж байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвд Атар өргөө ХК, АПУ ХК, Говь хангай мебель, Оюуны хөрөнгө оруулалтын академи, Скай сервисис ХХК, Жүр үр ХХК, Блүфин сүлжээ ресторан, Сентрал экспресс си ви эс ХХК, Таван богд групп, Оюу дарь эх ХХК, Цагаан хуаран СӨХ, Их Монгол СӨХ-өөс хөгжлийн бэрхшээлтэй иргэний **156** нээлттэй ажлын байрны захиалга авч, **40** иргэнийг бүртгэж, зуучилснаас **35** иргэн ажилд орсон.

Ажлын байрны өдөрлөг

Хөдөлмөрийн өдөрлөг яармагийг тайлант хугацаанд **39** удаа зохион байгуулсан. Үүнээс Хүний нөөцийн бүрдүүлэлтийн өдөрлөгийг 21 удаа зохион байгуулсан байна.

• Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих өдөрлөгийг 2022 оны 02,03,04,05 дугаар саруудад нийт 4 удаа зохион байгуулж, 12 ажил олгогч байгууллагыг оролцуулж, ажил хайгч 81 иргэнийг бүртгэж, 35 иргэнийг байнгын ажлын байранд зуучилан ажилд оруулсан байна.

- 2022 оны 02 дугаар сарын 16-ны өдөр Техник технологийн дээд сургуулийн “Төгсөгчдийн өдөрлөг”-г хамтран зохион байгуулсан ба Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвд бүртгэлтэй ажил олгогч 11, Эй Би Өү Интернэшнл ХХК, Хүрд ХХК, Эко констракшн ХХК, Шилэн хийц ХХК, Премиум групп ХХК, Андын зам констракшн ХХК, Жой тройзон ХХК, Өндөр Алтайн зам ХХК, Рокмон ХХК, Юуна күйзен ХХК, Тэсо корпораци ХХК, Оюун хөрөнгө оруулалтын академи, Хас бар ХХК зэрэг нийтдээ 18 ажил олгогчийг оролцуулан хүний нөөцийн бүрдүүлэлт хийсэн.

2022 онд төгсөж байгаа 498 төгсөгчөөс **320** төгсөгч ажил хайгч иргэнээр бүртгүүлж, 45 төгсөгч байнгын ажлын зуучлагдсан, мөн тус өдөрлөгийн үеэр сургуулийн удирдлагууд ажил олгогчдыг хүлээн авч, уулзалт хийсэн. Уулзалтын үеэр хамтран ажиллах санамж бичиг байгуулж, төгсөгчдөд ажлын урилга гардуулав.

- “Хотын иргэний жил”-ийн хүрээнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хүртээмж, үр ашгийг нэмэгдүүлэх, алслагдсан дүүрэг, хороодын иргэд, хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг иргэдэд хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, арга хэмжээг нэг цэгээс үзүүлэх, ажлын ярилцлагад цахимаар хамруулах, ажил олгогчид шаардлагатай хүний нөөцөө бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдөр Нийслэлийн Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих хөгжлийн төвд “Ажлын байрны цахим өдөрлөг”-ийг танхим, цахимаар хослуулан зохион байгуулж, Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн ажил хайгч иргэд болон хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдсан иргэдийг оролцууллаа. Өдөрлөгөөр:

  - Ажилд зуучлагдсан иргэн 21
  - Зөвлөгөө, мэдээлэл авсан 83
  - Ажлын байрны захиалга 1443
  - Бүртгүүлсэн ажил хайгч 55
  - Бүлгийн сургалт танхимаар хамрагдсан иргэн 29
  - Бүлгийн сургалтад цахимаар хамрагдсан иргэн 21
  - Төсөл хөтөлбөр танилцуулга, мэдээлэл, зөвлөгөө авсан иргэн 55

Өдөрлөгт Нийслэлийн Нийгмийн халамжийн газар, Нийслэлийн Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих төв, Сүхбаатар дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, Чингэлтэй дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, Скай сервисис ХХК, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн хороод оролцож үйл ажиллагаагаа сурталчилан, иргэдэд хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр хэрэгтэй мэдээлэл зөвлөгөө, сургалтыг хамтран зохион байгуулаа.

Дэлхий нийтээр жил бүрийн тавдугаар сарын нэгний өдрийг “Олон улсын Хөдөлмөрчдийн эв санааны нэгдлийн өдөр” болгон тэмдэглэсээр ирсэн түүхтэй. Энэ өдрийг дэлхийн 140 гаруй улс оронд хөдөлмөрчид өөрсдийн эрх ашгийг хамгаалахад эвлэлдэн нэгдэж, эрх баригчид болоод ажил олгогч нарт дуу хоолойгоо хүргэдэг уламжлалтай. 2022.05.01-нд Монголын хуульчдын холбооноос зохион байгуулсан “Хуульчийн про боно өдөр 2022” өдөрлөгт оролцож, ажлын байрны мэдээлэл хүргэж, ажил хайгч **50** иргэнийг бүртгэж, ажлын байр санал болгож ажилласан.

Өдөрлөгт Монголын хуульчдын холбооны бүтцийн байгууллагууд, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын Ерөнхий прокурорын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Хүний эрхийн үндэсний комисс, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Архивын ерөнхий газар, Хууль зүйн туслалцааны төв, Нотариатчдын танхим, Нийслэлийн Хөдөлмөр Эрхлэлтийн газар, Нийслэлийн Нийгмийн халамжийн газар, Нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар болон холбогдох бусад төрийн, төрийн бус байгуулагууд оролцож, иргэдэд хууль, эрх зүйн зөвлөгөө, мэдээлэл, үндсэн үйлчилгээг нэг дороос үзүүлсэн.

Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газар иргэдэд Хөдөлмөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, төсөл хөтөлбөрийн талаарх зөвлөгөө, мэдээлэл, ажилд зуучлах үйлчилгээг үзүүлэн оролцсон.

2022.05.15-нд Говь-Алтай аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраас Хил хамгаалах ерөнхий газарт зохион байгуулсан “Төрөлх Алтайн хөгжилд-Залуусын оролцоо” хөдөлмөрийн яармагт оролцож, ажлын байрны танилцуулга, хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэл хүргэж, 100 гаруй иргэдэд зөвлөгөө мэдээлэл өгч, **41** иргэнийг ажил хайгч иргэнээр бүртгэж, ажлын байр санал болгож ажиллалаа.

2022 оны 05 дугаар сарын 17-ны өдөр Чингис хааны нэрэмжит Их засаг их сургуулийн төгсөгчдийн ажлын байрны өдөрлөгт оролцож, хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэл, эрэлттэй байгаа ажлын байрны захиалгыг 500 гаруй төгсөгчдөд танилцуулж, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг нэг цэгээс үзүүлж, 29 төгсөгчид ажлын байр санал болгож, зөвлөгөө, мэдээлэл өгч ажиллалаа.

<u>Хүний нөөцийн бүрдүүлэлт, өдөрлөг</u>

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийн ажил олгогчийн танхимд ажил олгогч, ажил хайгч иргэд хооронд анхан шатны ярилцлага шууд хийж, ярилцлагын үр дүнг иргэдэд тухай бүр өгч, чирэгдэл багатай зохион байгуулдгаараа онцлог үйлчилгээ бөгөөд төвөөр дамжуулан ажил олгогчийг дэмжих зорилгоор Хүний нөөцийн бүрдүүлэлтийн аяныг 2022 оны 01 дүгээр сарын 12-ны өдрөөс 2022 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн хугацаанд **21** удаа зохион байгуулж, өдөрлөгөөр **1442** ажлын байр зарлагдснаас **522** ажил хайгч иргэн байнгын ажлын байранд зуучлагдсан. Үүнд:

- Зарласан ажлын байр **1442**
- Ажлын ярилцлагад орсон иргэн **1357**
- Тэнцсэн ажилд орсон иргэн **522**
- Тэнцээгүй иргэн **184**
- Ажиллах хүчний нөөцөд бүртгэгдсэн иргэн **241**

Үүнээс 2 удаагийнх нь гадаадад өндөр мэдлэг ур чадвар эзэмшсэн иргэд, гадаадад ажиллаж байгаад ирсэн иргэдийг ажилд авах хүсэлтэй Монголын алт ХХК, Таван богд Вашёкү ХХК нийт 758 ажлын байр танилцуулан оролцсон ба тус өдөрлөгт 287 иргэнийг ажлын ярилцлагад хамруулж, зөвлөгөө мэдээллээр ханган ажилласан.

Мөн 5 удаад нь орон нутагт үйл ажиллагаа явуулдаг ажил олгогчийг оролцуулж, **920** нээлттэй ажлын байрыг танилцуулж, хөдөө орон нутагт ажиллах боломжтой **371** ажил хайгч иргэнийг ажлын шууд ярилцлагад оруулж, **153** иргэн тэнцэж, хөдөө орон нутагт ажиллах байнгын ажлын байраар хангагдсан байна.

<u>Онлайн зуучлалаар</u>

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвд бүртгэлтэй ажил хайгч иргэдийн мэдээллийг ажил олгогч байгууллагад цахим хэлбэрээр илгээж, ажлын ярилцлагад хамруулах замаар онлайн зуучлалын үйлчилгээг үзүүлдэг ба энэ нь ажил олгогч, ажил хайгч иргэн, хөдөлмөр зуучлалын байгууллага хоорондын мэдээлэл солилцох үйл явцыг хөнгөвчлөх, цаг хугацааг

хэмнэх олон талын ач холбогдолтой юм. Тус үйл ажиллагааны хүрээнд нийт **871** иргэний мэдээллийг ажил олгогч **193** байгууллагад илгээж, санал болгосон байна.

Бүртгэл, мэдээлэл

Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийг улсын хэмжээнд ашигладаг http://lmis.gov.mn/ болон Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газрын https://job.opensoft.mn/ бүртгэлийн системийн мэдээллийн санд бүртгэл үүсгэж ажилласан.

Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, хөнгөвчлөх зорилгоор ажил хайгч иргэн, ажил олгогчид зориулан Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газрын https://job.opensoft.mn/ бүртгэлийн системтэй холбосон **UB JOB** гар утасны аппликейшнээр **105** ажил хайгч иргэн бүртгүүлж, үйлчилгээ авсан байна.

Байгууллагын албан ёсны www.ubbirj.ub.gov.mn цахим хуудас, “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв” болон “Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газар” фэйсбүүк хуудаснуудаар **190460** иргэнд, 131896 тусгай дугаарын www.smsservice.opensoft.mn/ үйлчилгээгээр **11987** иргэнд нийт **202447** иргэнд хөдөлмөр эрхлэлтийн талаарх мэдээ, мэдээллийг хүргэсэн байна. Энэхүү үйлчилгээ нь хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, иргэд хоорондын эргэх холбоог сайжруулах, механик ажиллагааг багасгах, үйлчилгээг шуурхай хүргэхэд ач холбогдолтой байна.

Хөдөлгөөнт бирж

Алслагдсан дүүрэг, хороодын ажил хайгч иргэдэд хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, арга хэмжээг нэг цэгээс үзүүлэх, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор 2022.05.03-нд “Хөдөлгөөнт бирж”-ийг Чингэлтэй дүүргийн алслагдсан хороодын иргэдийг хамруулан Чингэлтэй дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн дэргэдэх Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний загвар төвд зохион байгуулж, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, арга хэмжээг нэг цэгээс үзүүлж, **56** иргэнд мэдээлэл зөвлөгөө өгч, ажил хайгч **12** иргэнийг бүртгэн ажлын байр санал болгов.

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ АРГА ХЭМЖЭЭ

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс 2021-2022 онд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 7 хөтөлбөр, 28 арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан. Тус байгууллага нь нийслэлийн хэмжээнд 5 хөтөлбөрийн 12 арга хэмжээг дүүргүүдийн ХХҮХ-тэй хамтран 13.0 мянгаас доошгүй иргэнийг хамруулан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 3.9 тэрбум төгрөг зарцуулахаар ажиллаж байна. **Үүнд:**

- Аж ахуй эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр;
- Ногоон ажлын байр хөтөлбөр;
- Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр;
- Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр;
- Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр.

“Аж ахуй эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр”

Өрхийг гэрээт малчнаар ажиллуулах арга хэмжээ

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.2.8-д “Хотоос хөдөө рүү шилжин суурьшиж байгаа иргэдийг малжуулах” бодлогын хэрэгжилтийг хангах үүднээс Аж ахуй эрхлэгчдийг дэмжих хөтөлбөрийн “Өрхийг гэрээт малчнаар ажиллуулах арга хэмжээ”-г нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлэхээр үйл ажиллагааг үе шаттайгаар зохион байгуулж байна.

2022 онд 41 өрхийг хамруулахаар төлөвлөсөн ба гэрээт малчин өрхөөр ажиллах хүсэлтэй иргэдийн судалгааг Нийслэлийн гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, 9 дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсүүдээс, ажил олгогч малчны судалгааг 21 аймгийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраас тус тус авч нэгтгэн гэрээт малчнаар ажиллах хүсэлтэй 611 иргэн, гэрээт малчин ажиллуулах хүсэлтэй 1356 ажил олгогч малчны судалгааг гаргасан.

Тус арга хэмжээнд хамрагдах иргэдийг 2022 оны 05 дугаар сарын 15-ний өдрөөс хүлээн авч, ганцаарчилсан зөвлөгөө мэдээллийг өгч, үйлчлүүлэгчийн хөдөлмөр эрхлэхэд бэлэн байдлын үнэлгээг 14 өрхийн 28 иргэнд хийж хөдөлмөр эрхлэх хувийн төлөвлөгөөг боловсруулан, бичиг баримтын бүрдлийг хангаж, гэрээ байгуулахад бэлтгэсний дагуу **14** өрх **7** аймгийн **14** сум руу шилжин суурьшиж, 2022 оны 06 дугаар сарын 14-ний байдлаар **5** өрх гэрээ байгуулан гэрээт малчнаар ажиллаж байна.

“Финтекээр богино хугацааны эргэлтийн хөрөнгийн дэмжлэг олгох” арга хэмжээ

Аж ахуй эрхлэгчдийг дэмжих хөтөлбөрийн Финтекээр богино хугацааны эргэлтийн хөрөнгийн дэмжлэг олгох арга хэмжээний 4.1.2.3-д заасны дагуу финтек технологи ашиглан орчин үеийн шинэлэг, цахим хэлбэрээр автоматжуулан иргэн, аж ахуйн нэгжид дамжуулан зээлдүүлэх байгууллагыг сонгох сонгон шалгаруулалтын үйл ажиллагаа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд явагдаж байгаа ба шалгарсан байгууллагатай гэрээ байгуулах бэлтгэл ажил хангагдаж байна.

“Ногоон ажлын байрыг дэмжих хөтөлбөр”

Мод тарих арга хэмжээ

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг хангахад болон байгаль орчинд ээлтэй үйл ажиллагааг дэмжих, ажилгүй иргэдийн оролцоог хангаж, тэдний орлогыг нэмэгдүүлэх зорилгоор “Ногоон ажлын байр хөтөлбөр”-ийн мод тарих арга хэмжээг 2022 онд 200 иргэнийг хамруулан зохион байгуулахаар ажиллаж байна.

Мод тарих арга хэмжээг зохион байгуулах болон бүртгэлийн үйл ажиллагааны зарыг байгууллагын цахим хуудсанд байршуулсны дагуу 2 төрийн бус байгууллага мод тарих хүсэлтээ ирүүлсэн ба "Эрүүл мэндээрээ гоёцгооё" ТББ Баянзүрх дүүргийн 18-р хороотой хамтран 148-р сургуулийн орчинд 20 ажилгүй иргэнийг хамруулахаар, "Хотын хөгжлийг дэмжих шинэ тосгон ТББ" Сонгинохайрхан дүүргийн 24-р хороотой хамтран "Бумбатын рашаан"-ны орчинд тус хорооны ажилгүй 10 иргэнийг хамруулахаар хүсэлт ирүүлснийг судалж, урьдчилсан хяналтыг хийж байна.

Нийтийг хамарсан ажил зохион байгуулах арга хэмжээ

Байгалийн гамшиг, гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй бусад нөхцөл байдлын улмаас үүссэн хор уршгийг арилгах, нөхөн сэргээх, нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайд бүтээн байгуулалт хийх, сайжруулах, тохижилт хийх, хог хаягдалгүй байлгах, байгаль орчныг хамгаалах, ой цэвэрлэх, мод тарих, зэрэг үйл ажиллагаанд 2022 онд 150 ажилгүй иргэнийг хамруулж, түр ажлын байраар хангаж, орлогын дэмжлэг үзүүлэх зорилгоор “Нийтийг хамарсан ажил зохион байгуулах арга хэмжээ”-г хэрэгжүүлэн ажиллаж байна. 2022 оны хагас жилийн байдлаар нийтийг хамарсан ажил зохион байгуулах арга хэмжээг 2 удаа зохион байгуулж нийт 70 иргэнийг хамруулж Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас ажилласан хөлсийг олгосон.

“Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр”

Хөдөлмөр эрхлэлтийн танхимын сургалт зохион байгуулах арга хэмжээ

Орлого багатай өрхийн ажил эрхлээгүй насанд хүрсэн гишүүдийг мэргэжил эзэмшүүлэх, ур чадварыг ахиулах ажлын хүрээнд хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2022 оны 01 дүгээр тогтоолоор батлагдсан “Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр”-ийн Хөдөлмөр эрхлэлтийн танхимын сургалтад 2022 онд нийт 1000 иргэнийг хамруулахаар бэлтгэл ажлыг ханган, тус арга хэмжээг хамтран зохион байгуулах эрх бүхий 28 сургалтын байгууллагатай гэрээ байгуулж, Нийслэлийн төвийн 6 дүүргээс суралцах иргэдийн судалгааг нийгэм, эдийн засгийн 5 үзүүлэлт, 59 мэргэжлийн дагуу авч нэгтгэхэд 1361 иргэн суралцах хүсэлт ирүүлсэн байна. Суралцах чиглэлээр нь ангилвал:

Суралцах чиглэлээр нь ангилбал:



Хүсэлт ирүүлсэн иргэдийн ихэнх хувь нь үсчин, гоо сайхан, оёдолын чиглэлээр сургалтад хамрагдахаар хүсэлт ирүүлсэн байна.

Боловсролын байдал



Бүртгүүлсэн иргэдийн 72 хувь нь бүрэн дундаас доош боловсролтой иргэд байна. 2022 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн байдлаар 6 сургалтын байгууллагад 8 чиглэлээр 197 иргэн суралцаж байна.

Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр

Шилдэг Старт-Ап залуучуудад санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээ

Шинэ технологи, инновац шингээсэн гарааны бизнес эрхэлж буй залуучуудад гарааны санхүүжилт олгох, мэргэжлийн менторууд, бизнес эрхлэгчдээс зөвлөгөө авч бизнесээ илүү боловсронгуй болгох боломжийг бүрдүүлж, анхан шатны санхүүжилтийг олгох, бизнес санааг нь сурталчлан таниулах, дэмжих зорилготой “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн Шилдэг “Старт-Ап” залуучуудад санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээг Нийслэлийн хэмжээнд зохион байгуулахаар бэлтгэл ажлыг ханган, газрын даргын 2022 оны А/11 тоот тушаалаар ажлын хэсэг байгуулан хамтран зохион байгуулахаар хүсэлт ирүүлсэн 6 байгууллагаас сонгон шалгаруулж эрх бүхий 3 байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулаад байна.

Тус арга хэмжээнд хамрагдах хүсэлтэй залуучуудыг 2022 оны 05 дугаар сарын 27-ны өдрөөс 06 дугаар сарын 13-ны өдрийг дуустал бүртгэж байгаа бөгөөд 2022 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн байдлаар 478 залуучууд бүртгүүлээд байна. Хөтөлбөр үргэлжилж байна.

Оюутан, залуучуудыг цагийн ажилд зуучлах арга хэмжээ

Тус байгууллагын дэргэдэх “Цагийн ажлын бирж” нь оюутан, залуучуудыг цагийн ажилд зуучлах арга хэмжээг нийслэлийн хэмжээнд 17 их дээд сургуулийн дэргэдэх “Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв”-тэй хамтран зохион байгуулан ажиллаж байна. Хөтөлбөрийн хүрээнд цагийн ажил хийх хүсэлтэй 1739 оюутан, залуусыг бүртгэн, 131 ажил олгогч байгууллагаас 1577 цагийн ажлын байрны захиалга хүлээн авч, 1661 оюутан, залуусыг түр болон цагийн ажлын байраар хангасан байна.

Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр

Хүүхэд харах үйлчилгээний төв байгуулахад санхүүгийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээ

“Эмэгтэйчүүдийн ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн “Хүүхэд харах үйлчилгээний төв байгуулахад санхүүгийн дэмжлэг үзүүлэх” арга хэмжээг зохион байгуулах бэлтгэл ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэж байна. Үүнд:

Хүүхэд харах үйлчилгээний төв байгуулах хүсэлтэй, Хүүхэд харах үйлчилгээний тухай хууль тогтоомжийн шаардлагыг хангасан иргэний боловсруулсан төслийг хэрэгжих үндэслэлийг харгалзан шалгаруулж, 10.0 хүртэл сая төгрөгийн эргэн төлөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгийг 36 сарын хугацаатайгаар нэг удаа олгох ба олон нийтэд ил тод мэдээллэх зорилгоор төсөл хүлээн авах зарыг байгууллагын цахим хуудаст байршуулж, 2022.05.11-27-ны хугацаанд зохион байгуулсан.

Мөн Нийслэлийн Хүүхэд гэр бүл залуучуудын хөгжлийн газарт албан бичиг хүргүүлж, хүүхэд харах үйлчилгээний төв ажиллуулж байгаа болон ажиллуулахаар зөвшөөрөл авсан эмэгтэйчүүдийн судалгааг авсан. Судалгаагаар нийт 4 дүүргийн 64 төвийн мэдээллийг хүлээн авсан.

3.2. БИЧИЛ БИЗНЕСИЙГ ДЭМЖИХ, ЯДУУРЛЫГ БУУРУУЛАХ НИЙСЛЭЛИЙН ХӨТӨЛБӨР

Бичил бизнес эрхлэгчдэд хөнгөлөлттэй зээл олгох зорилгоор НИТХ-ын 2014 оны 16/17 дугаар тогтоолоор батлагдсан “Бичил бизнесийг дэмжих, ядуурлыг бууруулах нийслэлийн хөтөлбөр”-ийг нийт 150 хороонд хэрэгжүүлж, Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл авсан 123 хадгаламж зээлийн хоршоогоор дамжуулан 3479 иргэний төсөлд **14,3** тэрбум төгрөгийн санхүүжилтийг Бичил бизнесийг дэмжих нийслэлийн сангаас 2014-2016 оны хооронд олгосон.

ҮЗҮҮЛЭЛТ	БНД	БХД	БГД	БЗД	НД	СХД	СБД	ХУД	ЧД	НИЙТ
Иргэд байгуулсан ХЗХ	5	2	1	24	4	28	20	16	17	**117**
Үйл ажиллагаа явуулж байсан ХЗХ	-	-	22	4	3	4	-	-	1	**34 хороо**
Санхүүжилт авсан хороод	5	2	23	27	7	32	20	16	18	**150**
Олгосон санхүүжилт	**0,4**	**0,2**	**2**	**2,6**	**0,7**	**3,1**	**1,8**	**1,5**	**1,7**	**14,3 тэрбум**

	Шийдвэрлэсэн төслийн тоо	Санхүүжилт
2014 он	**221**	**939,500,000**
2015 он	**2721**	**11,010,049,500**
2016 он	**537**	**2,358,250,500**

Санхүүжилтийг эргэн төвлөрүүлэх ажлын талаар:

“Бичил бизнесийг дэмжих Нийслэлийн сангийн зөвлөл”-ийн 2017 оны 05 дугаар тогтоолын дагуу “Бичил бизнесийн дэмжих, ядуурлыг бууруулах нийслэлийн хөтөлбөр”-ийн хүрээнд олгосон санхүүжилт буюу Бичил бизнесийг дэмжих Нийслэлийн сангийн хөрөнгийг 24-36 сарын үе шаттай буцаан төвлөрүүлэх ажлыг зохион байгуулан хэрэгжүүлж байгаа ба эргэн төлөлтийг дараах байдлаар төвлөрүүлсэн байна.

Он	Эргэн төвлөрсөн дүн	Хүүгийн орлого /төгрөг/
2015 – 2016	-	171,358,325
2017	141,000,000	133,140,452
2018	3,151,760,001	125,551,242
2019	2,180,011,838	68,693,368
2020	833,173,176.78	34,071,189.95
2021	438,082,734	25,825,521
2022	401,088,064	18,339,574
Нийт	**7,219,315,352**	**580,523,280**

2022 оны 6 дугаар сарын 15-ны байдлаар Бичил бизнесийг дэмжих нийслэлийн санд нийт **7,219,315,352** төгрөгийг буцаан төвлөрүүлсэн. Хэрэгжилт 50%-тай байна.

Өмгөөллийн үйлчилгээний “Файт Партнерс” ХХН, Цэцэн заргач ХХН, Хэм консалтинг ХХН-тэй хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ байгуулан хамтран ажиллаж, нийт **3,037,341,843** төгрөгийг нэхэмжлэн нэр бүхий **57** хадгаламж, зээлийн хоршоог иргэний хэргийн анхан шатны шүүхэд шилжүүлсэн.

Хадгаламж, зээлийн хоршооны гишүүдийг сургалтад хамруулсан байдал

Олон Улсын Хөгжлийн Агентлаг (USAID)-ийн “Жижиг дунд бизнесийн тогтвортой хөгжлийг сайжруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх” (BEST) хөтөлбөрөөс болон Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн төв төсөл, Зээлийн батлан даалтын сантай хамтран зохион байгуулсан “Ажлын байрыг дэмжих 3% хүүтэй зээлд хамрагдах тухай” цахим сургалт “Мөнх агро шим” ТББ-аас зохион байгуулсан “Өрхийн тариалан, мини хүлэмж байгуулах зэрэг 5 удаагийн сургалтад давхардсан тоогоор **15** хадгаламж, зээлийн хоршооны **56** иргэн хамрагдаж, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль болон бусад төрлийн мэдээллээр хангасан.

Иргэдийн үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнийг борлуулалтыг нэмэгдүүлэх чиглэлээр

Чингэлтэй дүүргийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтэстэй хамтран 2022 оны 03 дугаар сарын 11-ний өдөр "ДЭМ ДЭМЭНДЭЭ" явуулын үзэсгэлэн худалдааг Нийслэлийн өмчийн 1 дүгээр байранд зохион байгуулж, **15** хөгжлийн бэрхшээлтэй бичил бизнес эрхлэгч иргэн бараа бүтээгдэхүүнээ сурталчилан оролцож **1.304.000** төгрөгийн борлуулалт хийсэн.

3.3. ЗАЛУУЧУУДЫГ ХӨДӨЛМӨРТ БЭЛТГЭХ ТӨСӨЛ

Залуучуудад эрүүл, эртэч, идэвхтэй амьдралын хэв маяг, эх оронч үзлийг төлөвшүүлэн сургалт зохион байгуулж, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх замаар хөдөлмөрт бэлтгэж, ажилтай, орлоготой болгоход төслийн зорилго оршино.

E-mongolia системд Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх “Оролцоо” төсөлд оролцохоор бүртгүүлсэн залуучуудын мэдээллийг **oroltsoo.hudulmur-halamj.gov.mn** программ автоматаар нас, хүйс, харьяалал, боловсролын түвшинг харгалзан хийсэн ба үүний дагуу Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газрын албан хаагчид Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн гадна талбайд бүлэг хуваарилалтын дагуу оролцогчдыг сургалтын хотхонууд руу хуваарилах ажлыг 2022 оны 06 дугаар сарын 09-ний өдөр зохион байгуулж, төслийн нэгдүгээр ээлжийг Зэвсэгт хүчний 119 дүгээр анги дахь Хуурай замын цэргийн сургалтын төвд эхлүүлсэн.

1 дүгээр ээлжид **240** оролцогчийг хуваарилан сургалтын хотхонууд руу явуулсан ба үүнээс эмэгтэй **153** оролцогч байна. Мөн 18-25 насны **153** оролцогч, 26-30 насны **69** оролцогч, 31-35 насны **40** оролцогч оролцож байна.

Бизнес аялал

Төслийн вакумжуулсан сургалтад хамрагдсан залуучуудад бизнесийн байгууллага тэр дундаа бодит үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай танилцах, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, ажлын байрны урьдчилсан төсөөлөлтэй болж бараа бүтээгдэхүүнтэй танилцах, мэдээ, мэдээллээр хангуулах.





Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх “Оролцоо” төслийн 1 дүгээр ээлжийн үйлдвэртэй танилцах аяллыг Эйч ар клуб ТББ хамтран 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдөр 2 байршилд буюу Милко ХХК-ийн шингэн болон хуурай хүнсний үйлдвэр, TML ХХК-ийн шингэн хүнсний үйлдвэрүүдэд зохион байгуулсан. Оролцогчид бүлгийн удирдагчдаа төслийн 5 дахь өдрөөс өмнө сонголтын хуудсаар аялалд оролцохоо илэрхийлсэн ба

төслийн 7 дахь өдөр аялалд оролцсон. Оролцогчдод мэдээллийг ижил өгч, санал авах хугацааг хатуу баримталж, оролцогчдыг тэгш хамруулах зарчмыг баримталж ажиллалаа.

Тус ээлжид нийт **90** оролцогчийг давхардсан тоогоор 10 үйлдвэрлэлтэй танилцуулах ажлыг зохион байгуулсан. Үйлдвэрлэлтэй танилцах аялалд хамрагдсан оролцогчид амжилттай ажиллаж буй ажилтны туршлага, байгууллагын онцлог, үйлчилгээний стандарт,

соёл, амжилтад хүрсэн түүх, ажлын байрны зохион байгуулалт, үйлдвэрлэлийн орчин нөхцөл, тоног төхөөрөмж, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн явцтай танилцаж, харилцан яриа өрнүүлсэн ба доорх хөтөлбөрийн дагуу үйл ажиллагаа явагдсан.

Үйлдвэртэй танилцах аяллын хөтөлбөр

Хугацаа	Хийгдэх ажил	Хариуцах байгууллага
08:00	Сургалтын хотхоноос хөдлөх	БХЯ
09:30-10:00	Оролцогчдыг хүлээж авах	НХЭГ Эйч ар клуб ТББ Аж ахуйн нэгж байгууллага
10:00-12:30	Үйлдвэртэй танилцах аялал зохион байгуулах	НХЭГ Эйч ар клуб ТББ Аж ахуйн нэгж байгууллага
12:30-13:00	Оролцогчдыг үдэх	НХЭГ Эйч ар клуб ТББ Аж ахуйн нэгж байгууллага
13:00	Сургалтын хотхон руу хөдлөх	БХЯ

Ажил олгогчийн уулзалт

ЗОРИЛГО: Эрүүл, эртэч, идэвхтэй амьдралын хэв маяг, эх оронч үзлийг төлөвшүүлэх сургалтад хамрагдсан залуучуудад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, ажил олгогчдоос ирүүлсэн нээлттэй ажлын байртай танилцах, 14 хоногийн сургалтын дараах дадлагаар ажиллах аж ахуйн нэгж байгууллагаа олох.

Төслийн сургалтын 12 дахь өдөр зохион байгуулагдахаар нэгдсэн удирдамжид тусгагдсан Ажил олгогчтой хийх уулзалт, хөдөлмөрийн яармагийг 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдөр амжилттай зохион байгуулж, 31 ажил олгогчийн 1473 ажлын байрыг танилцуулж, 210 оролцогч ажлын ярилцлагад орсноос 73 оролцогч тэнцэж, дадлагажих гэрээ байгуулсан.

ХҮНСНИЙ НОГОО ТАРИАЛАХ ТӨСӨЛ

Халамжаас Хөдөлмөрт зорилтын хүрээнд Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/658 тоот захирамжийн дагуу Улаанбаатар Агро паркд Нийслэлийн төвийн 6 дүүргийн зорилтот бүлгийн хүнсний ногоо тариалах хүсэлтэй 645 иргэдийг бүлгийн зохион байгуулалтад оруулж, 43 га талбайд хүнсний ногоо тариалах төслийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Төслийн хүрээнд иргэд хүнсний ногоо тариалах арга барилд суралцан, хөдөлмөр эрхлэх дадал эзэмшиж, бие даан газар тариалан эрхлэх чадвартай болж, эрүүл хүнсээр гэр бүлийн хэрэгцээгээ хангаж, өөрөө өөртөө ажлын байр бий болгох замаар өрхийн орлогоо нэмэгдүүлнэ.

Төсөлд хамрагдах иргэдийн судалгааг төвийн 6 дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсүүдээс 2022.05.11-2022.05.25-ны хугацаанд зохион байгуулж, нийт **410** иргэний бүртгэлийг урьдчилсан байдлаар хүлээн авсан.

Тус иргэдэд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох бүлгийн болон ганцаарчилсан сургалт, зөвлөгөөг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвөөр дамжуулан 2022.05.27-2022.06.03-ны хугацаанд зохион байгуулж, бүлгийн ахлагчийг сонгон гэрээ байгуулсан.

Төслийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлын хүрээнд “Улаанбаатар” Агро паркийн ойр орчмын хогийн цэвэрлэгээг хийж, хүлэмжийн гялгар уутнуудыг сольж хэвийн ажиллагааг хангасан.

Мөн усны болон хөрсний шинжилгээг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын төв лабораторт хүргүүлсэн, шинжилгээний хариу хэвийн гарсан.

Тариалалтын үйл ажиллагааны бэлтгэл ажлыг хангах зорилгоор 2022 оны 06 дугаар 13-ны өдрөөс ил талбайн газрыг хагалах ажлыг зохион байгуулж байна.

3.4. СУДАЛГАА

Тус газар нь 2022 оны эхний хагас жилийн байдлаар дараах судалгаануудыг хийж, үр дүнг нэгтгэж ажиллалаа.

1.Нийслэлд нийт 66861 аж ахуйн нэгж байгууллага үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд үүнээс 27501 аж ахуйн нэгж буюу 41% нь бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ, 7495 аж ахуйн нэгж буюу 11.2% нь үйлчилгээний бусад үйл ажиллагаа, 6363 аж ахуйн нэгж буюу 9.5% нь барилгын салбар байна. Хамгийн олон аж ахуйн нэгж байгууллага үйл ажиллагаа явуулж байгаа дүүрэг: Баянгол дүүрэг-13347 Баянзүрх дүүрэг-15010, Сүхбаатар дүүрэг-14197 байна.

Нийслэлд үйл ажиллагаа явуулж буй 66861 аж ахуйн нэгж, байгууллагын эдийн засгийн үйл ажиллагааны салбар, дүүргээр:

Мэдээллийн эх үүсвэр: Нийслэлийн Статистикийн газар 2022 он

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	**Нийт**	**БН**	**ХД**	**БГД**	**БЗД**	**НД**	**СХД**	**СБД**	**ХУД**	**ЧД**
Нийт	**66861**	**506**	**80**	**13347**	**15010**	**752**	**7571**	**14197**	7863	**7535**
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	882	14	2	83	133	17	99	214	150	170
Уул уурхай, олборлолт	842	6	1	99	176	10	65	307	111	67
Боловсруулах үйлдвэрлэл	3597	30	6	576	753	57	553	787	524	311
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	57	2	1	12	8	1	1	13	16	3
Усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	77	2	1	8	18	4	9	13	13	9
Барилга	6363	14	2	1193	1911	51	1024	1021	600	547
Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар үйлчилгээ	27501	185	18	5857	5457	298	3459	5316	3620	3291
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	1373	9	3	383	294	14	231	185	159	95
Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	1432	18	4	205	362	40	123	342	157	181
Мэдээлэл, холбоо	1903	[illegible]	[illegible]	378	466	10	106	543	141	255
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	1696	47	[illegible]	193	311	20	109	451	170	394
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	996	[illegible]	[illegible]	182	163	5	100	324	113	105
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	4181	17	[illegible]	822	972	14	294	1188	437	435

Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	3119	11		897	671	31	229	657	307	316
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа	395	18	2	23	63	23	34	77	34	111
Боловсрол	2743	23	4	524	638	34	290	473	326	431
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	1678	24	2	394	446	19	203	282	174	134
Урлаг, үзвэр, тоглоом наадам	496	8	3	98	98	6	27	113	78	65
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	7495	72	6	1420	2067	98	615	1866	728	613
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	35	0	0	0	3	0	0	25	5	2

2.Их дээд сургууль болон суралцагчдын статистик мэдээлэл

Манай улсад үйл ажиллагаа явуулж буй их, дээд сургууль, коллежийн тоо 2020-2021 оны хичээлийн жилд 88 байгаагийн 37 (42.1%) нь их сургууль, 45 (51.1%) нь дээд сургууль, 3 (3.4%) нь коллеж, 3 (3.4%) нь гадаадын их сургуулийн салбар байна. Үүний 65 (73.9%) нь төрийн бус өмчийн, 20 (22.7%) нь төрийн өмчийн, 3 (3.4%) нь олон нийтийн, шашны 1 өмчийн сургууль байна. Нийт сургуулийн 79 (89.8%) нь Улаанбаатар хотод, 9 (10.2%) хөдөө, орон нутагт байна. Их, дээд сургууль, коллежид суралцагчдын тоо 2019-2020 оны хичээлийн жилд 148.4 мянга байсан бол 2020-2021 оны хичээлийн жилд 147.3 мянга болж, өмнөх хичээлийн жилээс 1.1 (0.7%) мянгаар буурсан байна.

3.Техникийн болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага болон суралцагчдын статистик мэдээлэл

Манай улсад нийт 75 техникийн болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага үйл ажиллагаа явуулж байна. Үүний 36 байгууллага нь Улаанбаатар хотод байна. Эдгээр мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагыг дүүргээр нь авч үзвэл:



Нийслэлд үйл ажиллагаа явуулж буй 36 мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын 12 (33.3%) нь төрийн өмчийн, 24 (66.6%) нь төрийн бус өмчийн байгууллага

байна. Дээрх мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагад 20640 суралцагч 404 /давхардсан тоогоор/ мэргэжлээр суралцаж байна.

Техникийн болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагыг 2020-2021 оны хичээлийн жилд нийт 9.2 мянган оюутан төгссөн бөгөөд үүний 4.5 (49.4%) мянган төгсөгч ажлын байртай болж, 779 төгсөгч дараагийн шатны сургуульд дэвшин суралцаж байна.

Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам



4.“Эмэгтэйчүүдийн ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн цагийн ажилд зуучлах арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 0-3 хүртэлх насны хүүхдээ асарч байгаа цагаар ажил эрхлэх боломжтой эмэгтэйчүүдийн судалгааг 9 дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсүүдээс авч нэгтгэсэн. Тус судалгаагаар нийт 829 иргэний мэдээлэл ирсэн бөгөөд дүүргээр нь авч үзвэл:

- Багануур – 32
- Багахангай – 29
- Баянзүрх – 131
- Налайх – 71
- Сонгинохайрхан – 149
- Сүхбаатар – 149
- Хан-Уул – 74
- Чингэлтэй -194

5.https://job.opensoft.mn/ бүртгэл мэдээллийн системд дүн шинжилгээ хийсэн байдал

Тус бүртгэл мэдээллийн системд нийт 390 иргэн идэвхтэй ажил хайгчаар бүртгэгдсэн. Үүнээс бүтэн цагийн буюу байнгын ажил хайгчаар 30 иргэн, цагийн ажилд 360 иргэн бүртгүүлж, мэдээлэл зөвлөгөө авсан байна. Тэдгээрийг нас, хүйс, боловсрол, хайж буй ажлын үйл ажиллагааны салбараар ангилж үзвэл:

Нийт ажил хайгчийн 168 иргэн буюу 43% нь эрэгтэй, 222 иргэн буюу 57% нь эмэгтэй байна. Насны ангиллыг авч үзвэл: 15-34 насны 333 иргэн буюу 85%, 35-45 насны 34 иргэн

буюу 9%, 45-55 насны иргэн буюу 5%, 55 дээш насны 5 иргэн буюу 1%-ын үзүүлэлттэй байна.





Боловсролын түвшинг авч үзвэл: бүрэн бус дунд 0.7%, бүрэн дунд 93%, тусгай мэргэжлийн 2.3%, дээд 2.8%, магистр 0.3%-ын үзүүлэлттэй байна.

Ажилд зуучлуулсан иргэдийн тоон мэдээлэл

https://job.opensoft.mn/ бүртгэл мэдээллийн системд бүртгэгдсэн 389 иргэдийг нас, хүйс, зуучилсан байгууллагын үйл ажиллагааны салбарыг авч үзвэл: Нийт зуучилсан 389 иргэний 64%-ийг эмэгтэйчүүд, 36%-ийг эрэгтэйчүүд эзэлж байна.

Насны ангиллыг авч үзвэл: 17-25 насны 254 иргэн буюу 65%, 25-34 насны 54 иргэн буюу 14%, 35-45 насны 45 иргэн буюу 11.5%, 45-55 насны 26 иргэн буюу 6.7%, 55-аас дээш насны 10 иргэн буюу 2.6%-ийн үзүүлэлттэй байна.

Зуучлуулж орсон байгуулагуудыг үйл ажиллагааны салбараар нь авч үзэхэд: Боловсрол 0.7%, боловсруулах үйлдвэрлэл 26.2%, бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ 23.3%, үйлчилгээний бусад үйл ажиллагаа 44%, хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа 4.4% -ийн үзүүлэлттэй байна.



Нийт зуучилсан 389 иргэнээс 18 иргэн нь 2-4 удаагийн давтамжтай ажилд /цагийн ажил/ зуучлагдсан байна. Үүнд:

Эндээс үзэхэд цагийн ажилд хэд хэдэн удаа зуучлагдаж байгаа иргэдийн мэдээлэл давтамжаараа нэмэгдэж байна. Ажил хайгч иргэдийн 333 иргэн буюу 85% нь 15-34 насны, 93% нь бүрэн дунд боловсролтой гэсэн үзүүлэлттэй байгаа нь https://job.opensoft.mn/

бүртгэлийн системд оюутан залуучууд түлхүү бүртгүүлсэн нь харагдаж байна. Ажил хайгчдын 69% нь үйлчилгээний салбарын ажил хайж байна.

Аж ахуй нэгж, байгууллагын ажлын байрны захиалгыг авч үзэхэд: Үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбар 43%, боловсруулах үйлдвэрлэлийн салбар 16%, уул уурхай, олборлолтын салбар 15.4%, Хүний эрүүл мэнд нийгмийн халамжийн үйл ажиллагааны салбар 11.3%, барилгын салбар 9.2% -ийн үзүүлэлттэй байна. Нийт зуучилсан иргэний 44% буюу 171 иргэн нь үйлчилгээний салбар /нийтийн хоол, ресторан, худалдаа үйлчилгээ/-т ажилласан байна.

6.Сэтгэл ханамжийн судалгаа

Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн “Оюутан залуучуудыг цагийн ажилд зуучлах” арга хэмжээний хүрээнд цагийн ажил эрхлэх хүсэлтэй 202 иргэнээс сэтгэл ханамжийн судалгаа авсан бөгөөд тус судалгаанд 161 оюутан, 41 ажил хайгч иргэн хамрагдсан байна. Судалгаанд хамрагдсан нийт иргэдээс нас, хүйс, хөдөлмөр эрхлэлт, ажлын цаг, цагийн ажил хийх болсон шалтгаан, хэдэн төгрөгний цалин авдаг талаар асуухад: Судалгаанд хамрагдсан нийт иргэдийн 32% нь эрэгтэй, 68% нь эмэгтэй ба насны бүлгээр авч үзвэл 84% нь 18-25, 10% нь 26-35, 5% нь 36-45, 0.4% нь 46-55 насны иргэд байна.





Цагийн ажлын чиглэлээр авч үзвэл: 61% нь үйлчилгээний бусад үйл ажиллагаа (ачаа зөөх, бараа өрөгч, худалдагч, касс, зөөгч угаагч, бэлтгэгч, туслах ажилтан гэх мэт), 8% нь барилга, 4% нь судалгааны ажилтан, 27% нь цагийн ажил хийж байгаагүй гэсэн бол өдөрт ажилласан цагаар авч үзэхэд 55% нь 4 цаг, 41% нь 8 цаг, 4% нь 10 цагаас дээш гэж хариулсан байна.



Судалгааг дүгнэхэд хамрагдсан нийт иргэдийн 79% нь оюутан залуучууд байгаа бөгөөд 61% нь үйлчилгээний чиглэлээр цагийн ажил хийж байсан ба цагийн ажил хийх болсон шалтгааны хувьд 78% нь хэрэглээгээ ханган, 51% нь 300000 болон түүнээс доош төгрөгийн цалин авч ажилласан байна.

7.Хөдөлмөрийн зах зээлийн төлөв байдал

Нийслэлийн 9 дүүргээс хөдөлмөрийн зах зээлийн төлөв байдлын мэдээг сар бүр авч нэгтгэн, НЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэст хүргүүлэн ажиллаж байна. 2022 оны 05 дугаар сарын 31-ны өдрийн байдлаар:

Д/д	Нэрс	БНД	БХД	БГД	БЗД	НД	СХД	СБД	ХУД	ЧД	НХЭГ	НИЙТ
1	**Шинээр бий болсон ажлын байрны тоо**	15	10	246	378	42	656	347	236	212	0	**2142**
2	**Ажлын байрны захиалга өгсөн ААНБ-ын тоо**	39	9	240	112	10	76	30	169	18	167	**870**
3	**Ажлын байрны захиалгын тоо**	193	57	1130	1107	162	775	291	1560	73	3001	**8349**
4	**Бүртгүүлсэн иргэдийн тоо**	307	310	688	1506	134	1024	433	887	775	1475	**7539**
5	**Зуучилсан иргэдийн тоо**	118	53	358	274	79	765	173	340	117	2200	**4477**
6	**Үүнээс ажилд орсон иргэдийн тоо**	118	49	358	274	79	681	173	270	117	1652	**3769**
7	**Ажил мэргэжлийн чиг баримжаа олгосон иргэдийн тоо**	310	23	150	0	0	557	167	141	301	1377	**3026**
8	**Нийтийг хамарсан ажилд хамрагдсан иргэдийн тоо**	92	30	0	50	0	65	0	115	240	50	**642**
9	**Түр ажлын байр**	27	0	13	50	4	14	1	21	0	0	**130**
Цагийн ажил												
1	**Ажлын байрны захиалга өгсөн ААНБ-ын тоо**	0	0	7	0	0	9	0	0	0	131	**122**
2	**Ажлын байрны захиалгын тоо**	0	0	20	0	0	350	0	0	0	1577	**1249**
3	**Бүртгүүлсэн иргэдийн тоо**	0	0	0	0	0	87	0	61	2	1739	**1022**
4	**Үүнээс ажилд орсон иргэдийн тоо**	0	0	0	0	0	12	0	0	0	1661	**873**
Хөгжлийн бэрхшээлтэй иргэд												
1	**Бүртгүүлсэн иргэдийн тоо**	10	19	14	0	4	14	2	32	2	40	**137**
2	**Үүнээс ажилд орсон иргэдийн тоо**	0	1	4	0	0	0	0	11	1	15	**32**
Ажилгүйдлийн тэтгэмж												
1	**Ажилгүйдлийн тэтгэмж хүсэгчид**	113	16	1205	1360	140	1127	735	1358	614	0	**6668**

3.5. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖИЛ

Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас жил бүрийн 04 дүгээр сарын 28-ны өдрийг “Ажлын байран дахь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дэлхийн өдөр” болгон олон улсын хэмжээнд 2003 оноос хойш 18 дахь жилдээ тэмдэглэж байна.

Тус газар нь 2012 оноос эхлэн Хөдөлмөрийн аюулгуй байдал эрүүл ахуйн сарын аянг өрнүүлж, хууль тогтоомжийг сурталчлах, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх, ажилтны эрүүл мэндийг хамгаалах, ажлын байрны соёлыг төлөвшүүлэх, сургалт сурталчилгаа зохион байгуулах зэрэг олон арга хэмжээг авч хэрэгжүүлсээр ирсэн.

Энэ онд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн аяныг “Аюулгүй байдал, эрүүл мэндийн эерэг соёлыг хамтдаа төлөвшүүлье” уриатай зохион байгуулж, нийслэлийн 9 дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аяныг тэмдэглэн иргэдэд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийг сурталчлан таниулж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ, сургалт өдөрлөгийг зохион байгуулаа.



Арга хэмжээний хүрээнд Нийслэлийн хэмжээнд 224 аж ахуй нэгж байгууллагын 2514 ажилтан албан хаагчдыг хамруулан нийт 66 удаагийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны мэдлэг олгох, хандлагыг төлөвшүүлэх, урьдчилан сэргийлэх сургалт, 78 удаагийн үзүүлэх сургалт, 2 видео шторк бэлтгэн аж ахуй нэгж байгууллага иргэдэд сурталчлан цахим орчинд түгээн ажиллаа.

3.6. ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА

№	Үйл ажиллагаа	№	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Тайлбар /хэрэгжилт/
Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх						
1.	Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт	1.1.	Нийт сургалт, семинар, зөвлөгөөний тоо:	15	16	Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас зохион байгуулсан 4 цагаас дээш хугацааны 16 удаагийн сургалтад байгууллагын нийт албан хаагчдыг бүрэн хамруулсан. Тус газар нь 20 албан хаагчтай /эмэгтэй 15, эрэгтэй 5/ бөгөөд тайлант хугацаанд давхардсан тоогоор 66 албан хаагч /эмэгтэй 60, эрэгтэй 6/ тус тус сургалт, арга хэмжээнүүдэд хамрагдсан байна.
		Үүнээс	Ажлын байран дахь сургалт	10	11	
			Мэргэшүүлэх сургалт	5	5	
			Туршлага солилцох арга хэмжээ	-	-	
			Бусад	-	-	
		1.2.	Хамрагдсан нийт албан хаагчдын тоо:	20	20 /давхардсан тоо 66/	
		Үүнээс	Эмэгтэй албан хаагч	15	15 /давхардсан тоо 60/	
			Эрэгтэй албан хаагч	5	5/давхардсан тоо 6/	
			Удирдах албан тушаалтан	4	4	
			Гүйцэтгэх, туслах албан тушаалтан	16	16	
		1.3.	Албан хаагчдыг сургалтад хамруулсан байдал: Нийт албан хаагчдад эзлэх хувь	90-ээс дээш	80%	
2.	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хамруулсан гадаад сургалт	2.1.	Нийт гадаад сургалт, семинар, зөвлөгөөний тоо	0	0	Албан хаагчдыг хоёрдугаар хагас жилд гадаад улсад зохион байгуулагдах сургалт, арга хэмжээнд хамруулахаар төлөвлөсөн.
		2.2.	Хамрагдсан нийт албан хаагчдын тоо:	0	0	
		Үүнээс	Эмэгтэй албан хаагч	0	0	
			Эрэгтэй албан хаагч	0	0	
			Удирдах албан тушаалтан	0	0	
			Гүйцэтгэх, туслах албан тушаалтан	0	0	
		2.3.	Гадаад сургалтад хамруулсан байдал: Нийт албан хаагчдад эзлэх хувь	20-оос дээш	0%	
3.	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал, албан хаагчдын шилжилт хөдөлгөөн	3.1.	Албан хаагчдын сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг)	0.5	400.000	Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас зохион байгуулсан нийт 49 төрлийн 254 цагийн сургалтад давхардсан тоогоор 346 албан хаагчийг хамруулсан.
		3.2.	Албан хаагчдын шилжилт хөдөлгөөний хувь	15-аас доош	15%	Тус газар нь 20 албан хаагчтай бөгөөд нийт албан хаагчдын 15%-д шилжилт хөдөлгөөн хийгдэж, 85% нь тогтвор суурьшилтай ажиллаж байна. Үүний хүрээнд 2 албан хаагч өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдөх, 1 албан хаагч суралцах болсон тул төрийн албанаас түр чөлөөлөгдөх

						хүсэлтийг тус тус гаргасны дагуу Даргын 2022 оны Б/06, Б/12, Б/14 тоот тушаалуудаар үүрэгт ажлаас нь чөлөөлсөн.
Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах						
4.	Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх	4.1.	Цалин, шагнал, урамшуулалд зарцуулсан зардлын байгууллагын нийт төсөвт эзлэх хувь	100%	34.9%	Тус байгууллагын 2022 оны үйл ажиллагааны нийт төсөв **5,637,036,100** төгрөг ба үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалд **396,010,500** төгрөг зарцуулахаар батлагдсан. 2022 оны 05 дугаар сарын байдлаар **138,287,056** төгрөг зарцуулсан нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалд төсөвлөсөн нийт дүнгийн 34.9%-ийг эзэлж байна.
		4.2.	Нэгж албан хаагчид олгох хоол, унааны нэмэгдэл (мян.төг)	24,200,000	10,684,000	Нэг албан хаагчид хоногт хоолны 4500 төгрөг, унааны 500 төгрөгийн хөнгөлөлтийг олгодог ба 2022 онд нийт 20 албан хаагчид 24,200,000 төгрөг зарцуулахаар батлагдсан. 2022 оны 05 дугаар сарын байдлаар 10,684,000 төгрөг зарцуулсан байна.
5.	Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх	5.1.	Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн санал асуулгын дүн (Албан хаагчдын сэтгэл ханамж)	80-аас дээш		Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн санал асуулгыг жишиг загварт нийцүүлэн боловсруулж, хоёрдугаар хагас жилд авахаар төлөвлөсөн.
6.	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх	6.1.	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг (Жилд)	1-ээс дээш	2	Ажилтан, албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийг хоёрдугаар хагас жилд зохион байгуулахаар төлөвлөсөн.
		6.2.	Албан хаагчдын хамрагдалт	90-ээс дээш	100%	Тус шинжилгээнд байгууллагын нийт албан хаагчид сайн дурын үндсэн дээр хамрагдана.
7.	Албан хаагчдыг нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарцуулсан зардал	7.1.	Албан хаагчдын нийгмийн асуудалд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг)	399,010,500	139,649,856	2022 онд цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, нэг удаагийн тэтгэмж, дэмжлэгт нийт 399,010,500 төгрөг зарцуулахаар батлагсанаас 05 дугаар сарын байдлаар цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалд 138,287,056 төгрөг, нэг удаагийн тэтгэмж, дэмжлэгт 1,362,800 төгрөгийг тус тус зарцуулсан.

						“Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах 2022 оны төлөвлөгөө”-г батлан хэрэгжүүлсний дагуу Засгийн газраас баталсан цалингийн сүлжээг баримтлан үндсэн цалин, нэмэгдэл, урамшууллыг олгох болон бусад баталгааг хууль тогтоомжид нийцүүлэн ханган ажиллалаа. Тайлант хугацаанд байгууллагын нийт 20 албан хаагчид үндсэн цалинг тогтоосон хугацаанд олгосон ба 11 албан хаагчид төрийн алба хаасан хугацааны, 10 албан хаагчид зэрэг дэвийн, 2 албан хаагчид ажил хавсран гүйцэтгэсний, 3 албан хаагчид ур чадварын нэмэгдлийг тус тус зохих журмын дагуу олгосон. Үүний хүрээнд даргын 2022 оны А/01 дүгээр тушаалаар албан хаагчдын цалин нэмэгдэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн баталсан бөгөөд А/22 дугаар тушаалаар албан тушаалын зэрэг дэвийн нэмэгдлийг шинээр болон ахиулан олгов.

3.7. ИРГЭДЭЭС ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, АЛБАН БИЧГИЙН ШИЙДВЭРЛЭЛТ

Нийслэлийн хэмжээнд төрийн үйлчилгээний www.eservice.ulaanbaatar.mn дэд системийг бүрэн нэвтрүүлсэнтэй холбогдуулан тус Газрын хүний нөөц, цагийн бүртгэл, үүрэг даалгавар, өргөдөл гомдол, санал хүсэлт, хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, төсөв санхүү, албан бичгийн шийдвэрлэлт зэрэг бүхий л үйл ажиллагаа erp.ulaanbaatar.mn системээр хэрэгжиж байна.

Архивын ажлын хүрээнд:

✓ Архивын ажлын 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж холбогдох албан тушаалтнаар хэлэлцүүлэн батлуулсан.

✓ Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу байгууллагын зохион байгуулалтын нэгжүүдээс хүлээн авах, бүртгэх, ангилан төрөлжүүлэх, бүрэн бүтэн байлгах, удирдлагын үйл ажиллагаанд ашиглуулах, байнга хадгалах баримтыг сонгон, байгууллагын архивд хүлээн авсан. Нийт 149 хадгаламжийн нэгж байгууллагын архивд хүлээн авснаас байнга хадгалах 46, түр хадгалах 96, 70 жил хадгалах 7 хадгаламжийн нэгж байгаа бөгөөд данс, бүртгэл хөтлөн, ангилан төрөлжүүлсэн байна.

✓ 2021 оны газрын үндсэн үйл ажиллагааны 40 тушаал, хүний нөөцийн 36, нийт 76 тушаалыг Archive edoc программд шивэн цахим архив үүсгэсэн байна.



Өргөдөл, гомдол шийдвэрлэх ажлын хүрээнд:

✓ Газрын хэмжээнд нийт 17 /өссөн дүн/ өргөдөл ирснээс хуулийн хугацаанд бүрэн шийдвэрлэж ажилласан ба өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 5 хоног 23 цаг 6 минут байна.

✓ Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээ, тайланг 1 дүгээр улирлаар болон эхний хагас жилийн байдлаар гарган Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвд хүргүүлсэн.

Албан хэрэг хөтлөлтийн хүрээнд:

Газрын үндсэн үйл ажиллагааны чиглэлээр /А/ 24 /өссөн дүн/, хүний нөөцийн чиглэлээр /Б/ 19 /өссөн дүн/ нийт 43 тушаал гарсныг дугаар өгч, бүртгэн эх хувийг зориулалтын хатуу хавтсанд хадгалж байна.

✓ Газрын хэмжээнд нийт 488 /өссөн дүн/ албан бичиг ирснээс 89 нь хариутай бичиг, 399 нь хариугүй бичиг байна. Хариутай бичгийг хуулийн хугацаанд нь бүрэн шийдвэрлэсэн.

✓ Хариутай бичгийн шийдвэрлэлтийн хувь 99, хариугүй бичгийн хаалтын хувь 100, нийт ирсэн бичгийн шийдвэрлэлт 99%-тай байна.

✓ Тус газрын явсан албан бичгийн боловсруулалтад монгол хэл бичгийн дүрмийн дагуу баримт бичгийн стандартыг мөрдөж бүртгэн хариу ирүүлэгчийн байдалд хяналт тавьж ажилласан ба 2022 оны эхний хагас жилд нийт **179** /өссөн дүн/ албан бичгийг цахимаар боловсруулан холбогдох газруудад хүргүүлсэн.

Дотоод ажлын хүрээнд:

✓ 2022 оны эхний хагас жилд Нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөний 14 удаагийн 58 үүрэг даалгаврын биелэлтийг гарган Нийслэлийн засаг даргын тамгын газрын Ulaanbaatar.mn сайтад тайлагнасан.

✓ Нийгмийн салбарын удирдах албан тушаалтнуудын шуурхай хуралдааны 4 удаагийн 32 үүрэг даалгаврын биелэлтийг тухай бүрд гарган, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. Биелэлт 100% байна.

✓ Албан хэрэг хөтлөлтийн Edoc системийг ашиглан албан хаагчдад ирсэн бичгийн шийдвэрлэлт болон явуулж байгаа албан бичигт тухай бүрд хяналт тавин ажиллаж байна.

✓ Шийдвэрлэсэн албан бичгийг Edoc системийн хяналт цэсээр дахин баталгаажуулж үг үсэг, найруулгын алдааг хянан шалгасан.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

4.1. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр улсын хэмжээнд баримталж буй бодлого шийдвэрүүд, хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, зохион байгуулж буй арга хэмжээний талаарх мэдээ, мэдээллийг байгууллагын албан ёсны мэдээллийн сувгууд болон хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран иргэд, олон нийтэд сурталчлах ажлыг тасралтгүй зохион байгуулж ажилласан.

Энэ хүрээнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа болон шинэ төрлийн коронавирус /Covid-19/-ийн халдвараас урьдчилан сэргийлэх талаар холбогдох байгууллага, албан тушаалтнуудаас гаргасан тогтоол шийдвэр, мэдээ, мэдээлэл болон хөдөлмөр эрхлэлтийн мэдээ, мэдээллийг байгууллагын албан ёсны www.ubbirj.ub.gov.mn цахим хуудас, “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв” болон “Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газар” фэйсбүүк хуудсуудаар тайлант хугацаанд **341** мэдээ мэдээллийг байршуулж, **190460** иргэнд, 131896 тусгай дугаарын www.smsservice.opensoft.mn/ үйлчилгээгээр **11987** иргэнд, цахим зуучлалын үйлчилгээгээр **193** ажил олгогч, **871** иргэнд, UB JOB аппликейшнаар **105** иргэнд, нийт **191823** иргэнд хөдөлмөр эрхлэлтийн талаарх мэдээ, мэдээллийг хүргэсэн байна.

№	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хувь
Нэг. Үйл ажиллагааны ил тод байдал			
1	Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн, зохион байгуулалтын бүтцийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай, Хувь хүний нууцын болон Байгууллагын нууцын тухай, Төрийн нууцын тухай хуулиудын хэрэгжилтийг ханган, байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбарт эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүн, зохион байгуулалтын бүтэц, албан хаагчдын ажлын байрны жагсаалт зэрэг 264 гаруй нэр төрлийн мэдээллүүдийг байршуулан тухай бүр шинэчлэн ажиллалаа.	90%
2	Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Байгууллагын үйлчилгээ, захидал, харилцааны асуудлыг Дотоод ажил, архив, бичиг хэрэг, даргын туслах гүйцэтгэн ажиллаж байна. Байгууллагын цахим сайт, шилэн дансанд Газрын даргын “Б” тушаалууд, байгууллагын бүтэц, хүний нөөц, албан хаагчдын албан тушаал, и-мэйл хаяг, холбоо барих утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарь зэрэг мэдээ, мэдээллийг олон нийтэд ил тод байршуулан, тухай бүр шинэчлэн ажиллалаа. 2022 эхний хагас жилийн байдлаар Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газрын www.ubbirj.ub.gov.mn цахим хуудсаар хэрэглэгчдэд хөдөлмөр эрхлэлтийн газрын танилцуулга, видео, хөдөлмөрийн хууль тогтоомж, хэрэгжүүлж буй хөтөлбөр цаг үеийн мэдээ мэдээлэл, нийтлэл, хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой зар мэдээлэл зэрэг нийт 100 гаруй мэдээллийг оруулан **190460** хандалт авсан байна.	90%

3	Үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалтыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбарт Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс баталсан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн танилцуулга, бусад хөдөлмөр эрхлэлтийн арга хэмжээ, өдөрлөг яармаг, хэлэлцүүлгийн талаар мэдээллийг тухай бүр шинэчлэн байршуулж ажиллалаа. Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ, хөтөлбөрт хамрагдагсдад шаардагдах баримт, бичгийн бүрдлийн жагсаалтыг цахим хуудсанд байршуулсан.	90%
4	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг бэлтгэн байгууллагын ubbirj.ub.gov.mn цахим хуудас болон мэдээллийн самбартаа тогтмол байршуулан ажиллаж байна. 2022 онд Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм болон холбогдох бусад хууль, эрх зүйн актуудыг шинэчлэн байршуулсан. Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.9 дэх заалтын дагуу 100 ба түүнээс дээш ажилтантай хувийн хэвшлийн байгууллагуудаас КОВИД-19 цар тахлын үед хэвийн ажиллаж байгаа салбарын 50 аж ахуйн нэгж байгууллагатай холбогдож, Засгийн газрын 2020 оны 228 дугаар тогтоол болон оюутан суралцагчид, цагийн ажилтан ажиллуулах журмыг танилцуулж, цагийн ажлын байр зарлагдаж байгаа эсэхийг тодруулж мэдээлэл солилцож, хамтран ажилласан.	90%
5	Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон захиргааны хэм хэмжээний актын шийдвэрийн төслийг цахим хуудсандаа 30-аас доошгүй хоног ойлгомжтой байдлаар байрлуулж, холбогдох төрийн ба төрийн бус байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн, иргэдийн саналыг авах, үндэслэлтэй гэж үзвэл уг саналыг төсөлд тусгах;	Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газрын дүрэм болон холбогдох бусад хууль, эрх зүйн актад үндэслэн Газрын даргын 2021 оны А/12 дугаар тушаалаар байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг шинэчлэн баталж, байгууллагын албан ёсны www.ubbirj.ub.gov.mn цахим хуудсанд байршуулан нийт албан хаагчдад танилцуулж үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.	90%
6	Үзүүлж байгаа үйлчилгээний арга, хэлбэрийг боловсронгуй болгох зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх;	Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ үзүүлэх байгууллагад тавигдах MNS:6620-2016” стандартын дагуу хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ үзүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж буй үйлчилгээний арга, хэлбэрийг боловсронгуй болгох, зохион байгуулалтын арга хэмжээг шат дараатай авч хэрэгжүүллээ. Үүнд: Ажил хайгч иргэн, ажил олгогчид зориулсан хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг хөнгөвчлөх, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор https://job.opensoft.mn/ бүртгэлийн системтэй холбосон UB JOB гар утасны аппликейшнийг 2020 оны 01 дүгээр сараас үйлчилгээнд нэвтрүүлсэн. Энэхүү аппликейшн нь	90%

		ажил хайгч иргэд бүртгүүлэх, сонгосон хайлтаар мэдээлэл авах, ажил олгогч сул чөлөөтэй ажлын байрны мэдээллээ бүртгүүлэх зэрэг үйлчилгээг IOS, Android үйлдлийн системтэй бүх төрлийн гар утас, таблетаар ажлын цаг үл харгалзан авах, мэдээллийг аюулгүй, түргэн шуурхай солилцох боломжийг олгож байна. 2022 оны эхний хагас жилийн байдлаар UB job аппликэйшнээр нийт 105 иргэн үйлчилгээ авсан байна.	
7	Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу төрийн байгууллагын гүйцэтгэх тодорхой чиг үүргийг төрийн бус байгууллага гүйцэтгэж байгаа тохиолдолд тухайн төрийн бус байгууллагын нэр, хаяг, цахим хуудас, эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэлийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлэх;	Хөдөлмөр эрхлэлтийн Үндэсний зөвлөлөөс баталсан хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд эрх бүхий хөдөлмөрийн бирж, сургалтын байгууллагатай хамтран ажиллаж, сургалтын байгууллагуудын нэр, хаяг, цахим хуудас, эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэлийг мэдээллийн самбартаа байрлуулан, сурталчилж байна.	90%
8	Тухайн байгууллага тодорхой төрлийн аж ахуйн үйл ажиллагаа эсхүл бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгодог бол тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Тус байгууллага нь тодорхой төрлийн аж ахуйн үйл ажиллагаа эсхүл бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгодоггүй болно.	90%
9	Салбарын хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явц, байдлын талаарх мэдээллийг цахим хуудсандаа байрлуулан тухай бүр шинэчлэх;	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс 2022-2023 онд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 7 хөтөлбөр баталсан. Тус байгууллага нь нийслэлийн хэмжээнд 5 хөтөлбөрийн 12 арга хэмжээг дүүргүүдийн ХХҮХ-тэй хамтран хэрэгжүүлэхээр ажиллаж байна. **Үүнд:** • Аж ахуй эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр; • Ногоон ажлын байр хөтөлбөр; • Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр; • Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр; • Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр. Батлагдсан төсөл, хөтөлбөрүүдийн талаарх мэдээллийг байгууллагын ubbirj.ub.gov.mn цахим хуудсанд байршуулав.	90%

Хэсгийн дундаж хувь:			90%
Хоёр. Хүний нөөцийн ил тод байдал;			
1	Сул орон тооны зарыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх, энэ тухай олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах;	Тус байгууллага нь сул орон тоог нөхөх зорилгоор төрийн албаны тусгай шалгалт зохион байгуулах хүсэлтийг тухай бүр холбогдох мэдээллийн хамт Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөлд хүргүүлсэн. Нийслэлийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/1059 дүгээр захирамж гарч тус газрын зохион байгуулалтын нэгж өөрчлөгдсөнөөр албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлуулахаар Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт хүргүүлсэн. Албан тушаалын жагсаалт шинэчлэн батлагдсаны дараа албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, сул орон тоог нөхөхөөр ажиллаж байна. Тус газрын сул орон тоог холбогдох хууль тогтоомжийн хүрээнд нөхөж, **5** албан хаагчийг албан тушаалд томилсон.	90%
2	Албан хаагчийн ёс зүйн дүрмийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг 2022 онд байгууллагын ubbirj.ub.gov.mn цахим хуудас болон мэдээллийн самбарт шинэчлэн байршуулав.	90%
3	Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмыг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг байгууллагын ubbirj.ub.gov.mn цахим хуудсанд байршуулсан. Журмын 4 дүгээр хавсралтаар “Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг тайлагнах хүснэгтийг баталсан.	90%
4	Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх;	Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах зорилгоор дараах мэдээллүүдийг байгууллагын ubbirj.ub.gov.mn цахим хуудсанд байршуулав. Үүнд: - Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм” - “Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах 2022 оны төлөвлөгөө” - “Ажилтан, албан хаагчдыг 2022 онд чадавхжуулах сургалтын төлөвлөгөө” - Байгууллагын бүтэц, албан хаагчдын нэр, албан тушаал, өрөөний дугаар, цахим хаяг, утасны дугаар	90%
5	Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх;	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 8 дугаар хавсралтаар батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн тайлангийн загвар”, 9 дүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх аргачлал”, 10 дугаар хавсралтаар батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх үнэлгээний хуудсын загвар”-ыг тус тус байгууллагын ubbirj.ub.gov.mn цахим хуудсанд байршуулав.	90%
Хэсгийн дундаж хувь:			90%

Гурав. Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал			
1	Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан	2022 оны үйл ажиллагааны төсөв 5,637,0 сая төгрөг ба үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалд 396,0 сая төгрөг зарцуулахаар батлагдсан. 2022 оны 05 дугаар сарын байдлаар 138,2 сая төгрөг зарцуулсан нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалд төсөвлөсөн нийт дүнгийн 34.9%-ийг эзэлж байна. Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс баталсан хөтөлбөр арга хэмжээний хүрээнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд 1,209,0 төгрөгийн орлого орж ирснээс 2022 оны 06 дугаар сарын 15-ний өдрийн байдлаар 1,122.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.	90%
	Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт зөрчилгүй гарсан бөгөөд аудитын тайланг байгууллагын цахим хуудас болон шилэн дансанд байршуулсан.	90%
	Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны төсвийг зориуллалтын дагуу өр авлага үүсгэлгүй зарцуулан ажиллаж байна.	90%
	Таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг	Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий мөнгөн гүйлгээг тухай бүр, төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт, төсвийн гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлт, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, зэрэг мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд сар бүр 17 төрлийн мэдээллийг заасан хугацаанд тус тус байршуулан ажиллаж байна. Хагас жилийн байдлаар цахим хуудсанд нийт 37 төрлийн мэдээллийг баршуулж мэдээллээр ханган ажилласан.	90%
	Хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ	“Бичил бизнесийг дэмжих Нийслэлийн сан”-гийн зөвлөлийн 2017 оны 05 дугаар тогтоолын дагуу 2022 оны 01 дүгээр сарын 03-наас 2022 оны 06 дугаар сарын 08-ны хооронд 38 хадгаламж зээлийн хоршооноос нийт 419,427,638 төгрөгийн зээл төлөгдсөнөөс хүүгийн орлого 18,339,574 төгрөг, үндсэн зээлийн орлого 401,088,064 төгрөг төлөгдсөн байна.	90%
	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл шалтгаан	Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/658 дугаар захирамжийн дагуу хүнсний ногоо тариалах арга хэмжээг зохион байгуулах хүрээнд 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан цахим системд оруулж, Сангийн яамаар батлуулсан. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу даргын 2022 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн А/21 дүгээр тушаалаар “Үнэлгээний хороо” холбогдох хууль тогтоомж болон үнэлгээний хорооны шийдвэрийн дагуу, үрийн төмс нийлүүлэх НХЭГ/202205001 дугаартай тендерийг хуульд заасны дагуу зохион байгуулж, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл шалтгаан зэргийг Нийслэлийн худалдан авах ажиллагааны газрын tender.gov.mn сайтад тайлагнан ажиллаа.	90%
Хэсгийн дундаж хувь:			90%
Нийт дундаж			90%

ТАВДУГААР БҮЛЭГ. БУСАД МЭДЭЭЛЭЛ

5.1. ТҮНШЛЭЛ, ХАМТЫН АЖИЛЛАГАА

Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газар нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв, Цагийн ажлын биржээр дамжуулан байгууллагын үйл ажиллагааг сурталчлан таниулах, нийслэлийн хүн амын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх зорилгоор салбарын болон орон нутгийн холбогдох төрийн болон төрийн бус байгууллагууд, дүүрэг, хороод, албан бус салбартай уялдаа холбоотой хамтран ажиллаж, хамтын ажиллагаа, түншлэлийг бэхжүүлэхэд чиглэсэн олон талт ажлыг зохион байгууллаа. Тус ажлын хүрээнд:

- ✓ Тайлант хугацаанд хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний хүрээнд төр, хувийн хэвшлийн **298** ажил олгогч байгууллагтай хамтран ажиллаж, нийт 4578 ажлын байрны захиалгыг төвлөрүүлж, олон нийтэд мэдээлж ажилласан.
- ✓ http://lmis.gov.mn/, https://job.opensoft.mn/ системүүдийн хүрээнд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын Мэдээллийн технологийн төв, “Опенсофт” ХХК-тай системийн хэвийн ажиллагаа, шаардлагатай хөгжүүлэлт, сайжруулалтын чиглэлээр уялдаа холбоотой ажиллаж байна.
- ✓ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны талаарх мэдээллийг Нийслэлийн хэвлэл мэдээллийн алба, MNB TV, Монголын радио, Eagle TV, UBS TV, TV8, TV5, MN25, TV6, ETV, NTV телевиз, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны сайт, байгууллагын албан ёсны мэдээллийн сувгуудаар дамжуулан иргэд, олон нийтэд тухай бүр хүргэлээ.
- ✓ Баялаг бүтээгчдийг дэмжих холбоотой “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд чиглэсэн хөтөлбөрүүдэд баялаг бүтээгчдийг хамруулах, олон нийтэд мэдээлэх, нийгэмд тулгамдсан зарим асуудлыг холбогдох байгууллагуудаар шийдвэрлүүлэх зорилготойгоор хамтран ажиллах санамж бичиг байгууллаа. Нийслэлийн Хөдөлмөр Эрхлэлийн газрын дарга С.Нямдорж, Баялаг бүтээгчдийг дэмжих холбооны ерөнхийлөгч Ч. Даваабар нар гарын үсэг зурж баталгаажуулсан. Санамж бичигт гарын үсэг зурсны дараа “Баялаг бүтээгчдийг дэмжих холбоо”-ны Ерөнхийлөгч Ч.Даваабаяр “Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газар”-ын үйл ажиллагаатай танилцсан.



Санамж бичгийн хүрээнд талууд

- ✓ Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд чиглэн хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд баялаг бүтээгчдийг хамруулах,
- ✓ Дээрх чиглэлийн хүрээнд олон нийтэд мэдээлэл түгээх, өргөн хүрээнд зохион байгуулахад дэмжин ажиллах,
- ✓ 2022-2023 онд хэрэгжих Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 7 хөтөлбөрт нягт хамтран ажиллах,

- ✓ Санамж бичигт тусгагдсан асуудлаар үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөө гарган ажиллахаар тусгалаа.

✓ Хөдөлмөр эрхлэлтийн нийслэлийн зөвлөлийн хурлыг 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр зохион байгуулж, хурлаар 2022 онд нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлэх хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, хөтөлбөр арга хэмжээний төсвийг хэлэлцэн баталлаа. 2021 онд хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг танилцуулсан ба хуралд зөвлөлийн бүрэлдэхүүн оролцлоо.

✓ 2022 оны 02 дугаар сарын 17-ны өдөр Хөдөлмөр нийгмийн харилцааны дээд сургуультай хөдөлмөр, нийгмийн харилцааны чиглэлээр суралцаж буй төгсөх ангийн оюутнуудыг дадлагажуулах, төгсөгчдийг ажлын байранд зуучлах, хөдөлмөрийн салбарын албан хаагчдыг судалгаа, шинжилгээ, онол, арга зүйн сургалт, мэдээллээр хангах үйл ажиллагааг хамтран хэрэгжүүлэх зорилгоор хамтран ажиллах санамж бичгийг байгуулсан.

✓ "Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр"-ийн "Шилдэг старт ап залуу, залуучуудын багт санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээ"-нд 2021 онд Багануур дүүргээс шалгарсан "Уран бүргэд" багийн суран эдлэлийг Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газрын цахим хуудсанд нийтэлж, сурталчилан ажилласан ба тус мэдээлэл **2100** хүнд хүрсэн байна.

✓ Монгол Улсын Ерөнхий Сайдын санаачилгаар “Илүүдэл жингүй эртэч монгол” аянд нэгдэж, байгууллагын албан хаагчдын биеийн тамир, идэвхтэй хөдөлгөөний энгийн дасгал болох алхалт, гүйлтээр хичээллэхэд уриалах, таниулах, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, дасгал хөдөлгөөн тогтмол хийж, эрүүл амьдралын дадал хэвшилд суралцах зорилгоор зохион байгуулсан арга хэмжээнүүдэд нийт албан хаагчид идэвхтэй оролцсон.

✓ Монгол Улсын Ойн тухай хууль, Монгол улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар зарлигийн дагуу хэрэгжиж буй “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд “Ногоон хот-Иргэний оролцоо” хаврын мод тарих аянд нэгдэж, 2022 оны 05 дугаар сарын 06-ны өдөр 11.40-16.40 цагийн хооронд Сонгинохайрхан дүүргийн 24 дүгээр хороо, Баруун салааны

“Бумбатын булаг” байршилд 20 албан хаагч мэргэжлийн байгууллагаас өгсөн заавар, зөвлөмжийн дагуу ажиллаж, 30 ширхэг шар хуайс, 30 ширхэг хайлаас зэрэг нийт 60 мод тарьсан.

5.2. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙЖ АЖИЛЛАСАН ТУХАЙ

Бодлогын болон захирамжлалын баримт бичиг, байгуулллагын үйл ажиллагааны үр дүнг Монгол Улсын Засгийн Газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, 2021 оны 374 тоот тогтоол, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын Сайдын 2017 оны А/121 дүгээр тушаал, Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/335 дугаар тушаалаар батлагдсан журмууд, үнэлэх аргачлалын дагуу үнэлж дүгнэв. Мөн дээрх захирамжлалын баримт бичгүүдийг үндэслэн тус газрын хэлтсүүдийн гүйцэтгэлийн тайланд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийн ажиллаж байна.

2022 онд 15 заалт бүхий хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын төлөвлөгөө, тус байгууллагын 2021 оны Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангийн болон санхүүгийн үйл ажиллагаанд Нийслэл дэх төрийн Аудитын газраас өгсөн зөвлөмж, Нийслэлийн засаг даргын тамгын газраас тус газрын 2021 оны үйл ажиллагааны үр дүнг үнэлэх ажлын хүрээнд ирүүлсэн зөвлөмж, дүгнэлтийн дагуу гүйцэтгэл сайжруулах хариу арга хэмжээний төлөвлөгөө зэргийг боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2022 оны эхний хагас жилийн байдлаар тус байгууллагад хяналтын байгууллагуудаас тавигдсан акт, албан шаардлага байхгүй болно.

5.3. ДҮГНЭЛТ

Үндсэн үйл ажиллагааны хэрэгжилтийн үр дүн, цаг үеийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, цаашид ажлыг эрчимжүүлэх, сайжруулахад тасралтгүй анхаарч, мэдээллийн олон талт хэрэгслээр үйл ажиллагаагаа сурталчлан, төр-хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудтай түншлэл, хамтын ажиллагааг бэхжүүлэх чиглэлийг баримтлан ажиллаж байна.

"Хотын иргэний жил"-ийн хүрээнд иргэдэд төрийн үйлчилгээг ойртуулах, тэгш хүртээмжтэй нэг цэгээс үзүүлэх, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийн үйлчилгээний орчин, нөхцлийг сайжруулан, ажлын байрны өдөрлөг, арга хэмжээг тогтмол зохион байгуулж, ажил олгогчдыг дэмжин сурталчлан ажиллаж байна.

ТАНИЛЦСАН:

ГАЗРЫН ДАРГА С.НЯМДОРЖ

ХЯНАСАН:

БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГА Г.ГАНТҮШИГ

ТАЙЛАНГ НЭГТГЭН БОЛОВСРУУЛСАН:

БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ, ТОГТООЛ ШИЙДВЭР ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Г.ОДГЭРЭЛ